



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# “ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТ”

Судалгааны нэгдсэн тайлан

---

Улаанбаатар хот  
2015 он



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

## “ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТ” СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

Ажиглалтын үр дүнг боловсруулж, эмхэтгэж бичсэн:

Н.ТУЯА

МУИС-ын ХЗС-ийн Практик сургалтын тэнхимийн эрхлэгч

П.БАДАМРАГЧАА

Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хянан тохиолдуулсан:

П.БАДАМРАГЧАА

© Нээлттэй Нийгэм Форум

Уг тайланг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл  
дараах хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

# ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	4
ОРШИЛ .....	5
АЖИГЛАЛТЫН ДҮН .....	9
<b>А. Шударгаар шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилт.....</b>	<b>9</b>
1. Хууль ба шүүхийн өмнө тэгш байх эрхийн хэрэгжилт .....	10
2. Хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрхт, хараат бус, шударга шүүх байгууллагаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт.....	12
3. Нийтийн өмнө, нээлттэй шүүхээр шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилт .....	14
4. Гэм буруугүйд тооцогдох болон Дуугүй байх эрхийн хэрэгжилт .....	18
5. Шүүх хуралдааныг хойшлуулалгүй явуулах буюу зохимжтой хугацаанд шүүлгэх .....	20
6. Өөрөө өөрийгөө буюу өмгөөлөгчөөр дамжуулан өмгөөлөх эрхийн хэрэгжилт .....	23
7. Гэрчийг дуудах ба шалгах эрхийн хэрэгжилт.....	25
8. Хэлмэрч ба орчуулгын үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт .....	27
9. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй, хууль ёсны байх стандартын хэрэгжилт .....	28
<b>Б. Шүүх хуралдааны зарим онцгой субъектүүдийн оролцоо .....</b>	<b>30</b>
<b>В. Шүүхийн байрны тохижилт, хүндэтгэл төрүүлэхүйц байдал.....</b>	<b>35</b>
ХАВСРАЛТ.....	38
Шүүх хуралдааны ажиглалтын хуудас.....	38

## ӨМНӨХ ҮГ

Манай оронд өрнөж буй шүүхийн шинэтгэлийн үйл явцад хувь нэмэр болох зорилгоор Нээлттэй Нийгэм Форум анх 2010 онд Шүүхийн ажиглалтын төсөл хэрэгжүүлсэн билээ. Энэ удаагийн шүүхийн ажиглалтыг эрүүгийн хэргийн анхан шатны дөрвөн шүүхэд явуулж, иргэдийн шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт болон шүүхийн нөхцөл байдлыг шүүхийн тухай багц хууль батлагдахаас өмнөх үетэй харьцуулан, дүнг Та бүхэнд хүргэж байна.

Олон улсын хэмжээнд өргөн хэрэглэгдэж хүлээн зөвшөөрөгдсөн энэхүү шүүхийн ажиглалтын арга зүйг өөрийн нөхцөлд тохируулан боловсруулж турших ажил үр дүнтэй хэрэгжиж, цаашид шүүхийн мониторинг, ажиглалтын үйл ажиллагааг тогтмол, үр нөлөөтэй явуулах боломж бүрдэж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Шүүхийн ажиглалтын төслийг хэрэгжүүлэхэд гүн туслалцаа үзүүлж хамтран ажилласан Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан, Шүүхийн захиргааны удирдлагын газрын мониторинг хариуцсан референт Ч.Мөнхцэцэг, арга зүйн зөвлөхөөр ажилласан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын тэнхимийн эрхлэгч Н.Туяа, судлаач П.Анужин болон нийт ажиглагч оюутан, орон нутгийн иргэний нийгмийн ажилтнууддаа талархал илэрхийлье.

Шүүхийн ажиглалтын хүрээнд цуглуулсан мэдээлэл, хийсэн дүн шинжилгээ, гаргасан зөвлөмжийг шүүх болон шүүхийн захиргааны байгууллагууд, хуульчид анхааралтай авч үзэж, шүүхийн хараат бус, шударга, нээлттэй байдлыг хангах үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал

# ОРШИЛ

Шүүх эрх мэдлийн хүрээнд 2010 оноос эхэлсэн шинэтгэлийн үйл явц 2012 онд батлагдсан багц хуулиар шинэ шатанд гарсан билээ. 2013 оноос хэрэгжиж эхлээд байгаа Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиуд нь тогтолцооны хувьд томоохон өөрчлөлт шинэтгэлийг авчирсан. Энэ бүх хуулийн үзэл санаа бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх, тулгарч буй бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь шинэтгэлийг улам үр дүнтэй болгоход ач тустай юм. Энэхүү ажиглалтын үр дүн нь цаашид шүүхийн мониторинг болон тодорхой сэдвээр бодлогын судалгаа, шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох болно.

Энэхүү шүүхийн ажиглалт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал<sup>1</sup>, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар<sup>2</sup> баталгаажсан шударгаар шүүлгэх эрхийн стандартыг<sup>3</sup> дотоодын хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн практикт хэрхэн нийцүүлж ажиллаж байгааг ажиглах замаар шүүхэд хуулийн хүрээнд бие даан шударгаар ажиллахад учирч байгаа бэрхшээлийг тодорхойлж, зохих нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилготой. Шүүхийн ажиглалтаар дараах үндсэн асуудлыг авч үзлээ. Үүнд:

- Шударгаар шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилт
- Шүүх хуралдааны зарим онцгой субъектүүдийн оролцоо
- Шүүхийн байрны цэвэр цэмцгэр байдал, тохижилт зэргийг ажиглав.

Түүнчлэн 2010 оноос эхлэн эрчимтэй өрнөж буй шүүх эрх мэдлийн хүрээний шинэтгэлийн үр нөлөөг хэсэгчлэн үнэлэх нь энэхүү төслийн өөр нэг зорилт байв.

Шүүхийн ажиглалтын арга зүйг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчиллын институт, хүний эрхийн байгууллагаас Зүүн Европын болон Төв Азийн хэд хэдэн оронд амжилттай хэрэгжүүлсэн Шүүхийн

1 Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 6-14-р зүйл

2 ИБУТЭОУП-ын 9, 11, 14, 15, 16-р зүйл

3 Олон улсын Эмнести Интернэшнл байгууллагаас эрхлэн гаргасан “Шударгаар шүүлгэх эрх” гарын авлагыг харна уу - <http://www.amnesty.mn/mn/publications/shudargaar-shuulgekhe-erkh>

мониторингийн<sup>4</sup> арга зүйд тулгуурлан боловсруулсан. Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хувьд гарах шийдвэр нь хувь хүнийг гэм буруутай гэж үзэн үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөл байдал үүсдэг тул олон улсад эрүүгийн шүүх хуралд түлхүү ажиглалт хийдэг ажээ.

Шүүхийн үйл явцыг ажиглаж мэдээлэл цуглуулахдаа тодорхой тооны шүүхийг сонгон авч хянан хэлэлцэх хэрэг маргааныг доорх шалгуурыг үндэслэн сонгосон болно. Үүнд:

- Эрүүгийн шүүх хуралдаан байх,
- Анхан шатны хуралдаан байх,
- Шүүгдэгчийн тоо 3-аас дээшгүй байх ба
- Онц хүнд хэргээс бусад төрлийн хэрэг байх гэсэн шалгуураар сонгов.

Шүүхийн ажиглалтын мэдээлэл цуглуулах гол суваг нь тусгайлан бэлтгэгдсэн шүүхийн ажиглагчид байдаг. Бид ажиглагчдыг сонгохдоо дараах хоёр хандлага баримталлаа. Үүнд:

- Нийслэл хотод дүүргийн шүүхийн ажиглагчаар Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйн 4-р дамжааны оюутнуудыг (10 оюутан) сонгов. Тэд эрүүгийн эрх зүйн ерөнхий болон тусгай анги, байцаан шийтгэх эрх зүйн хичээлүүдийг үзэж судалсан байсан бөгөөд цаашид энэ чиглэлээр ажиллах хүсэлтэй, хууль зүйн клиник төвд идэвхтэй суралцаж байгаа зэрэг шалгуурын дагуу сонгогдлоо.
- Харин орон нутагт сум дундын 10, 23 болон 27-р шүүхэд эрх зүйн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг ажиллуулах боломжгүй байснаас гадна орон нутагт мэргэжлийн эрх зүйч, хуульчид цөөн байдаг тул мэргэжлээрээ ажиллаж буй хүмүүс сонгох боломжгүй байв. Тиймээс иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Төслийн зохицуулагч сонгон авсан орон нутаг бүрт биечлэн очиж тухайн орон нутагт байнга оршин суудаг, иргэний нийгмийн байгууллагад ажилладаг, шүүхийн ажиглалт, мониторингийн чиглэлээр ажиллах сонирхолтой иргэдээс сонгон шалгаруулж ажиллууллаа.

Нийт ажиглагчдын хувьд шүүгч, шүүхийн ажилтнууд, шүүх хуралдааны оролцогчидтой аливаа сонирхлын зөрчилгүй, өөрөө хэрэг, маргааны оролцогч бус байхыг шаардсан бөгөөд энэ талаар холбогдох, лавлагаа тодорхойлолтыг үндэслэн сонгосон болно.

Шүүхийн ажиглагчаар сонгогдсон иргэний нийгмийн төлөөлөгчдөд (12 иргэн) эрүүгийн эрх зүй болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн чиглэлээр нийт 16

---


4 <http://www.osce.org/odihr/94216> -ээс харна уу.

цагийн сургалт явуулж, шүүхийн үйл ажиллагаатай танилцах дадлага хийлгэж суурь мэдээлэл олгов. Мөн нийт 22 ажиглагч оролцсон арга зүйн сургалт зохион байгуулж уг сургалтад Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-ийн мониторинг үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн оролцож ажиглалтын арга зүйтэй танилцав. Түүнчлэн ажиглагчид танхимд олж авсан мэдлэгээ баталгаажуулж сургалтын үеэр туршилт ажиглалт хийв. Ийнхүү урьдчилан бэлтгэгдсэн ажиглагчид ажиллах шүүхийнхээ 7 хоног бүрийн шүүх хуралдааны товоос шалгуурт нийцсэн хуралдааныг сонгон ажиглаж Хавсралтад байгаа асуулгын дагуу мэдээлэл цуглуулав.

Энэхүү шүүхийн ажиглалтын төсөл нь (i) бэлтгэл, (ii) мэдээлэл цуглуулах, (iii) дүн шинжилгээ хийх, (iv) тайлан мэдээлэл боловсруулах гэсэн 4 үе шаттай хийгдсэн бөгөөд 2014 оны 11 дүгээр сараас 2015 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд үргэлжилсэн юм. Ажиглалтын үр дүнг боловсруулсны дараа дүн мэдээг нийтийн хүртээл болгох, холбогдох эрх бүхий байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх зэрэг нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн болно.

Шүүхийн ажиглалтыг нийслэлийн зүүн бүсийн анхан шатны 1-р шүүх, сум дундын 10 (Төв аймгийн Зуунмод суманд байрлах Сум дундын шүүх), 23 (Дорнод аймгийн Хэрлэн суманд байрлах Сум дундын шүүх) болон 27 (Хөвсгөл аймгийн Мөрөн суманд байрлах Сум дундын шүүх)-р шүүхийн эрүүгийн хэргийн шүүн хэлэлцэх хуралдааныг сонгон олон улсын хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд баталгаажсан шударгаар шүүлгэх эрхийн стандартыг удиртгал болгон явууллаа. 2014 оны 12 дугаар сарын 1-ээс 2015 оны 1 дүгээр сарын 16-ныг дуустал мэдээлэл цуглуулах ажиллагаа явагдсан бөгөөд эрүүгийн анхан шатны 4 шүүх дээр нийт 159 шүүх хуралдааны явцад ажиглалт хийснээс 62 хувь нь хөдөө орон нутгийн шүүхийн хурал байв (График 1.).

*Ажиглалтад хамрагдсан шүүх хуралдааны тархалт  
(шүүх тус бүрээр)*



Орон нутгаас судлагдсан шүүх хуралдааны 38 (23.9%) нь Хөвсгөлд, 31 (19.5%) нь Дорнодод, 30 (18.9%) нь Төв аймагт болжээ.

Шүүхийн ажиглалтын бэлтгэл шат буюу ажиглах шүүх болон шүүх хуралдааны талаар мэдээлэл авах нь чухал үе юм. Тэр дундаа мэдээллийг цахим хэлбэрээр авах нь иргэд, судлаачдын хувьд илүү дөхөмтэй байх хэдий ч шүүхүүдийн цахим хуудасны мэдээлэл тэр бүр шинэчлэгддэггүй, иргэдэд өгөх шаардлагатай мэдээллийн жагсаалт гаргах стандарт байхгүй тул цахим хуудас бүрийн мэдээллийн агуулга харилцан адилгүй байв. Мөн ажиглахаар зорьж очсон нийт 159 хурлын хоёрт нь шүүх хуралдааныг хаалттай явуулах шийдвэр гарсан, 59 хурал тодорхой шалтгааны улмаас хойшилж, нэгд нь ажиглагчдыг шүүх хурлаас гарахыг шаарджээ. Энэ бүхнийг тооцвол ажиглалтын дүнд нийт 97 хурал буюу нийт сонгосон хурлын 61 хувьд үндсэн үнэлгээг хийх боломжтой болсон юм.



# АЖИГЛАЛТЫН ДҮН

Шударгаар шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилт, шүүх хуралдааны зарим онцгой субъектүүдийн оролцоо, шүүхийн байрны цэвэр цэмцгэр байдал, тохижилт зэргийг ажигласан дүнг асуудал тус бүрээр бүлэглэн харуулав.

## А. Шударгаар шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилт

Шударгаар шүүлгэх эрх нь хүний жам ёсны үндсэн эрх бөгөөд процессын шинжтэй хэд хэдэн эрхийн нэгдмэл цогц байдаг. Энэхүү процессын эрхүүд нь (i) шүүхээс өмнөх шатны процесс, (ii) шүүхийн шатны процесс, (iii) онцгой субъектэд хамаарах процесс гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Энэхүү ажиглалтаар дээрх бүрэлдэхүүн хэсгүүдээс шүүхийн шатны процессын шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтэд төвлөрч үнэлгээ өгөв. Шударгаар шүүлгэх эрх нь хууль ба шүүхийн өмнө тэгш эрхтэй байх, хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрхт, хараат бус, шударга шүүх байгууллагаар хэргээ хянан шийдвэрлүүлэх, нийтийн өмнө нээлттэй шүүхээр шүүлгэх, гэм буруугүйд тооцогдох, дуугүй байх, эрүүгийн хуулийг буцаан хэрэглүүлэхгүй байх ба давхар ял оноолгохгүй байх, шүүх хуралдааныг хойшлуулалгүй явуулах буюу зохимжтой хугацаанд шүүлгэх, өөрөө өөрийгөө буюу өмгөөлөгчөөр дамжуулан өмгөөлүүлэх, анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд биеэр оролцох, гэрчийг дуудах ба шалгуулах, хэлмэрч ба орчуулгын үйлчилгээ авах, давж заалдах эрх болон шүүхийн шийдвэр нь үндэслэлтэй, хууль ёсны байх, шийтгэл нь хүний эрхийн стандартад нийцсэн, зохистой байх зэрэг стандартаас бүрддэг. Эдгээрээс доор дэлгэрүүлэн дурдсан 9 эрх, стандартыг л тодорхой түвшинд үнэлэх боломжтой байв. Учир нь шударгаар шүүлгэх эрхийг бүрэн цар хүрээгээр нь үнэлэхэд энэхүү ажиглалтын арга зүй дангаараа боломжгүй гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Бүрэн үнэлгээ хийхийн тулд шүүх хуралдааны явцаас гадна шүүхийн өмнөх болон дараах шатны процессын бүх мэдээлэлд үндэслэн нэмэлт судалгаа, дүн шинжилгээ хийх хэрэгтэй байдаг.

Сонгож авсан дээрх эрх, стандарт хэрхэн хэрэгжиж байгааг шүүхийн ажиглалтын асуулгын дагуу мэдээлэл цуглуулж үнэлгээг гаргалаа. Мөн шударгаар шүүлгэх

эдгээр эрх, стандарт нь харилцан нягт хамааралтай тул ажиглалтын дүн хэд хэдэн эрхэд хамаарч байгаа болно.

## 1. Хууль ба шүүхийн өмнө тэгш байх<sup>5</sup> эрхийн хэрэгжилт

Хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна гэдэг нь хуульд ялгаварлан гадуурхах зохицуулалт тусгахыг хориглохоос гадна шүүх ба бусад төрийн албан тушаалтан хууль хэрэгжүүлэхдээ хүмүүст ялгавартай хандаж харилцахыг хориглох тухай асуудал юм. Үүнд, хүн бүр шүүхийн өмнө тэгш эрхтэй байж нас, хүйс, шашин шүтлэг зэрэг хувийн байдлаас гадна оршин суугаа газраасаа үл хамааран тэгш эрхтэйгээр шүүхэд хандах, шүүн таслах ажиллагааны аль ч үед талуудын тэгш эрх хангагдаж байх үндсэн зарчим хамаарна.

### **Ажиглалтын дүн**

Шүүх хуралдаанд улсын яллагчаас хүсэлт гаргах үзүүлэлт нэлээд доогуур хувьтай байна (5.2%). Шүүгч улсын яллагчийн хүсэлтийг хэрхэн биелүүлж байгааг авч үзвэл 46.7 хувьд нь биелүүлж, 53.3 хувьд нь хүсэлтийг биелүүлэхээс татгалзжээ. Энэхүү татгалзлын үндэслэл нь юу байсныг судлахад яллах талын хүсэлтээр орон нутагт байгаа гэрчийг оролцуулахгүй, насанд хүрээгүй гэрчийн мэдүүлэг хавтаст хэрэгт байгаа учир шүүх хуралдаанд биечлэн оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байв. Шүүхийн хэлэлцүүлгийн үед улсын яллагч яллах дүгнэлтийг өөрчлөх тухай санал гаргах нь онцгой тохиолдолд тооцогддог. Гэтэл энэхүү судалгаанд хамрагдсан хэргийн 1.1 хувьд нь улсын яллагч яллах дүгнэлтээ өөрчилжээ.

Харин бүх хурлын явцад нийт өмгөөлөгчийн 68.8 хувь нь ялын асуудлаар санал гаргасан байна. Энэ үзүүлэлт бага биш боловч нийт өмгөөлөгчдийн 31.2 хувь нь өөрийн өмгөөлөлд байгаа хүний эрх ашгийг хамгаалж ялын талаар тодорхой санал тавиагүй байгаа нь санаа зовоох асуудал юм.

Улсын яллагч шүүгдэгчээс эхэлж мэдүүлэг авах ёстой бөгөөд энэ ажиллагаа хуулийн дагуу явагдаж байв. Түүнчлэн нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг тогтоохдоо өмгөөлөх, яллах талуудын саналыг авч байгаа нь сайшаалтай боловч 65.8 хувь нь яллах талын нотлох баримтыг эхний ээлжид судалжээ.

Шүүх хурал даргалагчийн зүгээс өмгөөлөх, яллах талуудад үг хэлэх боломжийг адил тэгш олгож байсан боловч харин шүүгдэгч эцсийн үгээ хэлэхэд нь ямар нэг саад бэрхшээл учруулж байсан гэж дүгнэжээ (5.4%). Түүнчлэн шүүгдэгч

---

5 МҮ-ын Үндсэн хуулийн 14-р зүйл, МҮ-ын Эрүүгийн хуулийн 5-р зүйл, МҮ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 14-р зүйл

өөрийгөө өмгөөлөх боломжийг нь хааж, хязгаарласан байдал нийт ажигласан шүүх хуралдааны 2.2 хувьд нь тэмдэглэгдсэн байна. Ажиглагчид энэхүү саад бэрхшээлийг тулгах, хөтөлж байцаах хэлбэрээр илэрсэн гэж үзжээ.

Шүүхийн мэтгэлцээний талаар ажиглагчид 79.4 хувь нь мэтгэлцээнийг идэвхтэй гэж үнэлсэн бол 20.6 хувь нь эсрэг үнэлгээ өгчээ.

*Шүүхийн мэтгэлцээний идэвхийг үнэлсэн байдал  
(2010 оны ажиглалттай харьцуулав.)*

Үзүүлэлт	2010 он	2015 он
Мэтгэлцээний үед шүүгчид хоорондоо ярилцан анхаарал нь төвлөрөхгүй байсан	40.6%	41.7%
Шүүх хуралдааны үеэр шүүгч гар утсаа ашиглан шүүх хуралдаанд бүрэн анхаарахгүй байсан	11.0%	8.3%
Бүрэлдэхүүний шүүгч хуралдаан эхэлсний дараа орж ирсэн	6.0%	5.1%
Шүүгч, хуралдааны нарийн бичиг, тахарын ажилтан хуралдааны дундуур орж гарах зэргээр шүүх хуралдаанд бүрэн анхаарч ажиллахгүй байсан	17.0%	13.3%

Ажиглалтын дүнд тулгуурлан хууль ба шүүхийн өмнө тэгш байх эрхийн стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Шүүх хуралдааны даргалагч шүүхийн мэтгэлцээн, нотлох баримт шинжлэх, хэлэлцүүлгийн зэрэг онц чухал үеүдэд болон шүүх хуралдааны явцад оролцогчдын анхаарлыг сарниулах аливаа дэг зөрчсөн үйлдлийг цаг тухай бүрт нь таслан зогсоож, шаардлагатай сахилгын арга хэмжээ авдаг байх;
- Шүүхийн захиргааны ажилтнууд шүүх хуралдааны үеэр ямар нэг байдлаар анхаарал сарниулах үйлдэл хийхгүй байх, энэ талаар шүүх хуралдааны оролцогчдоос гомдол санал хүлээн авах албан ёсны механизм бий болгох;
- Өмгөөлөгчдөд шүүх хуралдаанд улсын яллагчтай эрх тэгш оролцох боломж бололцоог холбогдох процессын хуульд оруулж өгөх буюу нотлох баримтыг шалгах, өмгөөлөх талын гэрч дуудах зэрэг үйл ажиллагааг идэвхжүүлэх хууль, эрх зүйн орчин бий болгох;
- Хууль ба шүүхийн өмнө адил тэгш байх эрхийн хэрэгжилтийг хангаж шүүгдэгч эцсийн үг хэлэх явцад ямар нэг саад бэрхшээл учруулахгүй байх;
- Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх тохиолдолд талуудын тэгш байдлыг хангах нөхцөлийг шүүх бүрэлдэхүүн бий болгох.

## 2. Хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрхт, хараат бус, шударга шүүх байгууллагаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт<sup>6</sup>

Шударга шүүхийн орших байх үндсэн зарчим, нөхцөл нь хэргийг шүүн тасалж буй шүүх байгууллага хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрхт, хараат бус, шударга байх явдал юм. Энэ утгаараа шүүхийн байгууллага нь улс төрийн аливаа нөлөөлөлд авталгүйгээр шийдвэр гаргах ёстой. Дээрх эрхийг хэрэгжүүлэхдээ шүүх нь “шударга ёсыг зөвхөн тогтоогоод зогсохгүй, тогтоосон шударга ёсоо харуулах ёстой” байдаг. Хэрэг хянан шийдвэрлэж буй аливаа шүүх байгууллага нь Үндсэн хууль болон түүний хүрээнд хууль тогтоогчоос баталсан шүүх байгуулах тухай бусад хууль, эсхүл нийтлэг эрх зүйн дагуу байгуулагдсан байж болно. Эрх бүхий шүүх бүрэлдэхүүнээр хэргээ шүүлгэх эрхтэй байна гэдэг нь тухайн хэргийг харьяалан шийдвэрлэх эрхтэй шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх тухай асуудал юм. Шударга шүүх байгууллагаар хэргээ шүүлгэх эрх нь шүүгч тухайн хэргийг шийдвэрлэхийн өмнө ямар нэгэн дүгнэлт гаргах буюу хөндлөнгийн сонирхолгүй байхыг шаарддаг. Шүүгчид шүүн таслах ажиллагааг үнэн зөв, талуудын эрхийг хүндэтгэх үндсэн дээр явуулах үүрэгтэй.

Шударга шүүхийн нэг гол үзүүлэлт нь шүүх хараат бус байх явдал мөн. Энэ нь шүүгч хэнээс ч хараат бусаар, төрийн байгууллагын болон хэн нэгний хөндлөнгийн дарамт, шахалтгүйгээр зөвхөн хуульд захирагдан хэргийг шийдвэрлэх тухай асуудал юм.

### ***Ажиглалтын дүн***

Иргэд шударга шүүхээр шүүлгэх эрхээ эдлэхийн тулд шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах эсэх талаар хүсэлт гаргах боломж нь хангагдсан байх ёстой. Ажиглалтын дүнгээс үзэхэд хуралдаан даргалагч нийт хуралдааны 97.1 хувьд нь шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргаж болох тухай тайлбарласан бол 2.9 хувьд нь энэ эрхийг тодорхой тайлбарлаж өгөөгүй байна. Ийнхүү шүүгч болон бусад оролцогчийг татгалзан гаргах эрхийг сайтар тайлбарлахгүй байгаа нь иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг нь үндэслэлгүйгээр хязгаарлахад хүргэх талтай. Шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийг тайлбарлах, уншиж сонсгох, уншиж сонсгосон яллах дүгнэлт шүүгдэгчийн гардаж авсантай таарч буй эсэхийг тодруулах ажиллагаа нь ажиглалтад хамрагдсан нийт аймаг, дүүргийн анхан шатны шүүхүүдэд хангалттай сайн байна. Нийт шүүх хуралдааны 3.0 хувьд нь л оролцогчдын эрх үүргийг ойлгомжтой тайлбарлаагүйг ажиглагчид тэмдэглэжээ.

<sup>6</sup> МУ-ын Үндсэн хуулийн 16.14, 47, 49-р зүйл, МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 15 -р зүйл

### Шүүгчийн харилцааны байдлын үнэлгээ

Асуултууд	Дүн
Шүүгч шүүх хуралдааны оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн	Тийм (97.0 %)
Шүүгч хэргийг алагчлалгүй шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрсөн	Үгүй (86.6 % <sup>10</sup> )
Шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгч шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан	Үгүй (94.8 % <sup>11</sup> )
Шүүгдэгчид гэм бурууг нь хүлээлгэхээр шүүгч дарамталсан	Үгүй (97.9 %)
Шүүгч шүүх хуралдааныг хурдан дуусгахаар хичээж байсан	Үгүй (96.8 %)

2010 онд хийсэн шүүхийн ажиглалтаар “бүрэлдэхүүнтэй шүүх хуралдааныг шүүх бүрэлдэхүүн бүрдээгүй байхад эхлүүлдэг, улмаар шүүх хуралдааны дундуур шүүгч орж гардаг. Мөн шүүгч хавтаст хэрэгт авагдсан баримт нотолгоо, өөрийн дүн шинжилгээ хийж боловсруулсан төсөөлөл болон мэтгэлцээний үр дүнг харьцуулан шийдвэр гаргах ёстой атал зарим тохиолдолд шүүх хуралдааны явцад мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй өөр бусад юм унших, зарим оролцогчийн ярьж буй зүйлийг таслан зогсоох буюу аль нэг талд ашигтай асуулт тавих” зэрэг сөрөг байдал нийтлэг ажиглагдаж байсныг баримтжуулсан байдаг.

Харин энэ удаагийн ажиглалтаар дээр дурдсан нөхцөл байдал сайжирсан нь анзаарагдсан ч хуралдааны үеэр шүүх бүрэлдэхүүн хоорондоо ярилцах, гар утсаа ашиглах, туслахаа дуудаж ярилцах, өөр хэргийн материал унших зэрэг шүүх хуралд бүрэн анхаарахгүй байгаа байдал тэмдэглэгджээ. Нийт ажигласан хурлын 94.8 хувьд шүүгч хуралдааны оролцогчидтой энгийн эелдэг байдлаар харьцаж байсан бол үлдсэн 5.2 хувьд хүйтэн хөндий, бүдүүлэг дээрэнгүй буюу ялгамжтай харилцаж байсан гэсэн дүгнэлт хийжээ.

Шүүгч шүүгдэгчийн эрхийг ойлгомжтой тайлбарлан сануулж, түүнд өөрийгөө өмгөөлөх зэрэг боломжийг сайн хангаж байсан. Шүүгдэгч өөрийгөө хангалттай илэрхийлж чадахгүй байгааг анзааран ярих боломжийг нээлттэй олгож байсан нь их сайшаалтай байсан.

Шүүх хурал эхлэх үед шүүгч залхуурсан, нойрмог байдалтай, хуралдааныг удирдахдаа идэвхгүй байсан тул хурал назгай байдалтай болж байв.

Прокурор, өмгөөлөгч болон шүүгч яарсан байдалтай байсан бөгөөд хурал маш хурдан явагдсан.

7 84 удаагийн шүүх хуралдаан

8 92 удаагийн хуралдаан

Хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрхт, хараат бус, шударга шүүх байгууллагаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн стандартын хүрээнд дараах Зөвлөмж гаргаж байна:

- Шүүгч олон нийтийн өмнө шударга ёс тогтоох үйл ажиллагааг удирдан явуулж байгаагийн хувьд шүүх хуралдаанд оролцогч, ажиглагч иргэдэд хүндэтгэлтэйгээр хандаж, аль нэг талыг барихгүй байх, улмаар аль нэг талд тал зассан мэт харагдах аливаа үг, үйлдэл гаргахгүй байх нь зүйтэй.
- Шүүгчийн зүгээс оролцогчдын эрх үүргийг дэлгэрэнгүй ойлгомжтой тайлбарлах, бусдад хүндэтгэлтэй хандах зэрэг нь иргэдийн хувьд эерэг гүнзгий сэтгэгдэл төрүүлж байгааг анхааралдаа авч энэ эерэг үйлдлийг түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй.
- Шүүгч хурлын дэгийг сахиулах, улсын яллагч, өмгөөлөгч нарын сахилга бат, хурлаас хоцрох, хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулах явдлыг таслан зогсоох зорилгоор шаардлагатай тохиолдолд Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуульд заасанчлан мэргэжлийн хариуцлагын асуудлаар холбогдох хороонд гомдол гаргах, сахилгын шийтгэл онгодуулах хүртэл арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.
- Шүүгч татгалзан гаргах эрхийг зөвхөн нэрлэх бус татгалзан гаргах үндэслэлүүдийг оролцогчдод тайлбарлаж хэвших хэрэгтэй.
- Шүүх хуралдааны бусад оролцогчийн эрх үүргийг (гэрч, хохирогч, шинжээч, хэлмэрч, орчуулагч) энгийн ойлгомжтой үг хэллэгээр тайлбарлах нь зүйтэй.
- Шүүх хуралдааны бүх үе шатанд шүүх бүрэлдэхүүн мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн ажиллахыг санал болгож байна.

### 3. Нийтийн өмнө, нээлттэй шүүхээр шүүлгэх эрхийн<sup>9</sup> стандартын хэрэгжилт

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах нь шүүхийн бие даасан, шударга байх нэгэн чухал үзүүлэлт бөгөөд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бататгах хамгаалалт болдог. Зарим нэг онцгой тохиолдлоос бусад үед шүүх хуралдааныг нээлттэй явуулах ёстой. Энэ нь мөн олон улсын стандартад тусгагдсан байдаг. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах нь зөвхөн хэргийн талуудад хамаараад зогсохгүй олон нийтийн эрх ашигт хамааралтай асуудал юм. Олон нийт шударга байдал хэрхэн тогтож байна вэ, шүүх үйл ажиллагаа ямар шийдвэрт хүрэв гэдгийг мэдэх эрхтэй байдаг билээ.

9 МУ-ын Үндсэн хуулийн 54-р зүйл, МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235-р зүйл

## Ажиглалтын дүн

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулах учиртай. Гэвч ажиглалтын явцад нээлттэй шүүх хуралдаанд жирийн иргэд чөлөөтэй нэвтрэн орох боломжийг хязгаарласан нь ажиглагдаж байсан. Тухайлбал, шүүх хуралдааны танхимд жирийн иргэд, ажиглалт хийж буй оюутнууд саадгүй нэвтрэн орохыг татгалзсан тохиолдол нийт ажигласан хурлын 20 хувийг эзэлж байна. Нээлттэй шүүх хуралдаанд саадгүй нэвтрэн орох эрхийг хязгаарласан тохиолдлын шалтгааныг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Нээлттэй шүүх хуралдаанд оролцох эрх хангагдсан байдал  
(2010 оны судалгааны дүнтэй харьцуулсан байдлаар)*

Асуулт	2010 он	2015 он
Шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй хүн бүрийг оруулсан	92.2%	91.2%
Шүүх хуралдаанд оруулсан хэдий ч тусгайлан зөвшөөрөл авах хэрэгтэй байсан	66.2%	23.3%

2010 онд хийсэн анхны ажиглалтын дүнтэй харьцуулахад тусгайлан зөвшөөрөл авах явдал буурсан үзүүлэлт харагдаж байна. Энэ удаагийн ажиглалтаар бид шүүх тус бүрийн Тамгын газрын дарга болон зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэнд урьдчилан төслийн талаар мэдэгдэж хамтран ажиллах тухай харилцан ойлголцолд хүрсэн байсан. Ийнхүү харилцан ойлголцсон хэдий ч шүүх хуралд ороход 23.3 хувьд нь ямар нэг зөвшөөрөл шаардаж байгаа нь нээлттэй байдал хангалтгүй байгааг бүрэн илтгэж байна. Нээлттэй шүүх хуралдаанд оролцох зөвшөөрлийг 2.8 хувь нь шүүгчээс, 33.3 хувь нь шүүхийн нарийн бичгийн даргаас, 25.0 хувь нь шүүхийн тахараас, 38.9 хувь нь шүүхийн захиргааны бусад ажилтнаас авсан байна. Мөн нээлттэй зарлагдсан шүүх хуралдаан талуудын хүсэлтийг харгалзан хаалттай болох тохиолдол цөөнгүй (4.7 хувь) байв.

Шүүх хуралдаанд хөндлөнгийн ажиглагчийг оруулахгүй байгаа голлох шалтгаан нь:

- Шүүх хуралдааны танхимын багтаамж муу.
- Субъектив шалтгаан нөхцөл (шүүх хуралдааны нарийн бичиг, шүүхийн тахар, шүүгчийн туслахаас хүсэлт гаргах, зөвшөөрөл авахыг шаардах, тухайн хэрэгт хамааралгүй иргэнийг оруулахгүй гэх мэтээр нээлттэй шүүх хуралдаанд оролцох эрхийг хангаагүй).

Шүүхийн ажиглалтын төслийн сургалтын явцад туршилтын анхны ажиглалт хийхээр Дүүргийн эрүүгийн анхан шатны 1-р шүүхэд очиход шүүхийн харуул тахар, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар хориглож, шүүхийн олон нийттэй харилцах ажилтан, зохион байгуулагчаас зөвшөөрөл авч орох шаардлага тавьсан. Тухайн ажилтантай ярихад албан хүсэлт гаргаж иргэний үнэмлэхийн хуулбараа авч ирээд цохолт хийлгэснээр шүүх хуралдаанд оролцох боломжтой гэсэн шаардлага тавьсан. Энэ шаардлагын үндэслэлийг лавлахад “Байгууллагын ил тод байдлын тухай” хуулийн дагуу шаардлага тавьж байна гэсэн хариу өгсөн болно. Монгол Улсын хэмжээнд ийм нэртэй хууль байхгүй бөгөөд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд ийм шаардлага байхгүй болно.

Шүүхийн тахар болон нарийн бичгийн дарга нь хэрэв Та оюутан бол шүүх хуралд суулгахгүй гэсэн. Ажиглагч гэдгээ хэлж, үнэмлэхээ үзүүлтэл “Өө за суу, суу” гэж инээмсэглэсэн. Мөн өөр бусад шүүхэд оролцох хүсэлтэй хүнийг хориглож байсан.

Даргалагч шүүгч биднийг хэн гэдгийг асуугаад тайлбар хүлээж авалгүй Тамгын газраас зөвшөөрлийн бичиг авчрах, тэр ч байтугай танхимаас гарахыг шаардсанаар бид хуралд сууж чадаагүй.

Шүүх хуралдаанд суух гэсэн боловч шүүгдэгчийн өмгөөлөгч “би оюутан суулгахгүй шүү” гээд гаргачихсан.

**Нээлттэй шүүх танхимын ажиллагаа:** Ажиглалтын төслийн хүрээнд ШЕЗ-ийн хүсэлтийн дагуу төсөлд хамрагдсан 4 шүүхэд 2015 оны 1 дүгээр сарын 12-оос 1 дүгээр 16-ны хооронд нээлттэй шүүх танхимын үйл ажиллагааг ажиглаж мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийлээ. Энэхүү ажиглалтын дүнг шүүх тус бүрээр авч үзье. Үүнд:

1. *Сум дундын 10-р шүүх:* Тус шүүх нь нээлттэй танхим огт ажиллуулдаггүй ба Шүүхийн хүлээлгийн хэсэгт 6 сандал, 1 дэлгэц байрлуулсан байдаг. Дэлгэц асаалттай байх бөгөөд телевизийн нэвтрүүлэг, кино гаргадаг гэж ажиглагчид тэмдэглэсэн байна. Шүүх хуралдааныг шууд нэвтрүүлэх талаар шүүхийн ажилтнуудын өгсөн тайлбар:

- *Шүүхийн харуул тахар:* Хэдийгээр нээлттэй хурал ч гэсэн Дорнод аймаг жижиг, цөөн хүн амтай тул бие биеэ ихэнх нь таньдгаас үүдээд нууцлалыг хангаж хурлын процессыг харуулдаггүй. Тоног төхөөрөмж нь байгаа, өөр том танхимтай болох гэж байгаа.
- *Шүүхийн мэдээлэл, технологийн ажилтан:* Хэргийн оролцогчдын хамаатан садангийн хүмүүс шүүх хуралд орох боломжгүй тохиолдолд



танхимаас үзүүлдэг. Бусад үед бусдын нууцлалыг хамгаалах үүднээс үзүүлэх шаардлагагүй гэж үздэг.

- *Шүүхийн тамгын газрын дарга*: Бүх зүйл нээлттэй байгаа тул та бүхэн танилцах бүрэн боломжтой гэж хариулсан байна.

2. *Сум дундын 23-р шүүх*: Тус шүүх нь нээлттэй танхим гэж тусдаа тохижуулаагүй бөгөөд хүлээлгийн хэсэгтээ 12 сандалтай ба 1 дэлгэц байрлуулсан байв. Шүүх хуралдааныг нэвтрүүлдэг хэдий ч дуугүй, зөвхөн дүрс л гаргадаг. 7 хоногийн турш эрүүгийн 8 шүүх хурал ажигласан бөгөөд бүгдийг нь дуугүй нэвтрүүлжээ.

3. *Сум дундын 27-р шүүх*: Энэ шүүхэд тусгайлсан нээлттэй танхим байхгүй. Шүүгчийн туслахуудын өрөөнд 1 дэлгэц байрлуулсан байдаг. Тус өрөөнд 3 туслах ажилладаг бөгөөд өрөөгөөр дамжин эвлэрүүлэн зуучлагчийн өрөөнд ордог зэргээс үүдээд ихээхэн хөдөлгөөнтэй, дуу чимээ ихтэй, зай талбай багатай байдаг. Шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтны зөвлөснөөр Тамгын газрын даргаас зөвшөөрөл авч шүүх хуралдааны нэвтрүүлэлтийг ажиглахаар болсон. Дэлгэцийг ажиллуулах үед шүүхийн туслахууд тохиргоо хийх, асаах зэргээр үйлчилж байсан ба техникийн ажилтан ирж туслалцаа үзүүлээгүй. Техникийн саатал, гаднын дуу чимээ ихтэй байдал, хурлын оролцогчид микрофонд хандахгүй зэргээс болж бүрэн сайн сонсох боломжгүй байжээ.

4. *Дүүргийн эрүүгийн 1-р шүүх*: Нээлттэй танхимаа шүүхийн байрны 1 давхарт тохижуулсан байсан бөгөөд 4 дэлгэц байрлуулан мэдээлэл хүргэж байв. Үүний 1 дэлгэц дээр шүүх хуралдааны товыг шинэчлэн гаргадаг бөгөөд үлдсэн дэлгэцүүдэд шүүх хуралдааныг харуулдаг. Тус танхим нь 10-аад сандалтай.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах стандартын хэрэгжилтийг ажиглаад дараах Зөвлөмжийг гаргаж байна:

1. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, шүүхийн тахарын албан хаагчдад шударга шүүхийн болон олон нийтийн өмнө нээлттэй шүүлгэх эрхийн ойлголт стандартыг олгох сургалт явуулах, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах;
2. Шүүх, шүүх хуралдааны нээлттэй байдлыг хангахад чиглэсэн нарийвчилсан стандарт, журмыг боловсруулж шүүх бүрт нэг мөр мөрдүүлэх;
3. Иргэдэд шүүх хуралдаанд хэрхэн оролцох талаар болон шүүх хуралдааны дэгийг танилцуулсан мэдээллийг бэлтгэж нийтэд хүртээмжтэй газар байршуулах;
4. Шүүхийн цахим хуудсын хөтлөлтийг идэвхжүүлж, иргэдэд шаардлагатай мэдээллээр баяжуулах, шүүх хуралдааны товыг тогтмол зарлахдаа нээлттэй зарлагдсан эсэх талаар оруулдаг байх;

5. Хэдийгээр холбогдох хуульд энэ талаар үүрэг болгоогүй ч шүүхийн тамгын газруудын зүгээс нээлттэй шүүх танхимын ач холбогдлыг үнэлэн үйл ажиллагааны хувьд жигдрүүлэх, тухайн орон нутгийн иргэдэд сургалт сурталчилгаа хүргэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө гарган ашиглах нь зүйтэй.

#### 4. Гэм буруугүйд тооцогдох болон Дуугүй байх эрхийн<sup>10</sup> хэрэгжилт

Шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндсэн зарчим нь шүүн таслах ажиллагааны үр дүнд хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэх буюу гэм буруутайд тооцохгүй байх явдал. Энэ эрх нь шүүх хуралдаанаас өмнө сэжигтнээр татаж, яллах дүгнэлт гарахаас эхлээд хяналтын шатны шүүхээр гэм бурууг нь тогтоох хүртэл хэрэгжинэ. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй буюу хэргээ албадан хүлээхгүй байх ба дуугүй байхтай холбогдсон эрхүүд нь гэм буруугүйд тооцогдох эрхээс урган гардаг. Яллах тал яллагдагчийн гэм бурууг нотлох үүрэгтэй бөгөөд түүний гэм бурууг гарцаагүй байдлаар нотолж чадахгүй бол яллагдагч гэм буруутан болохгүй. Ийнхүү шүүгдэгчийн гэм буруутайг гарцаагүй байдлаар тогтоож чадаагүй бол түүнийг цагаатгах ёстой.

Цагдаагийн байгууллагын байцаалтын болон шүүн таслах ажиллагааны үед дуугүй байх эрх нь гэм буруугүйд тооцогдох болон албадуулан гэм буруугаа хүлээхгүй байх буюу гэрчийн мэдүүлэг өгөхгүй байх гэсэн олон улсын түвшинд хамгаалагдсан хоёр эрхийн нэг хэлбэр юм. Төрлөөр устгах зэрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг зэрэг хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн байсан ч яллагдагч дуугүй байх эрхтэй.<sup>11</sup> Хэрэв шүүгдэгч ямар нэг байдлаар хүч хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан гэх гомдол гаргасан бол шүүгч тухайн гомдлыг байцаан шийтгэх ажиллагааны аль ч шатанд хүлээн авах бүрэн эрхтэй байх ёстой.

#### **Ажиглалтын дүн**

Шүүгдэгчийг тусгай хаалтын ард суулгаж байгааг ажиглагчдын 13.1 хувь нь шүүгдэгчийг бусдад гэм буруутай гэсэн урьдчилсан сэтгэгдэл төрүүлж байна гэж үзжээ. Энэ нь шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл шүүгдэгчийг гэм буруутайд тооцох ёсгүй гэсэн зарчимд харшилж буй хэрэг юм.

<sup>10</sup> МУ-ын Үндсэн хуулийн 16.14-р зүйл, МУ-ын Эрүүгийн хуулийн 4 -р зүйл, МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13-р зүйл

<sup>11</sup> Югославын дүрмүүдийн 42(A)(iii) дугаар дүрэм, Руандагийн дүрмүүдийн 42(A)(iii) дугаар дүрэм, Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийн 55(2)(b) дэх зүйл

Шүүх хуралдааны явцад мэтгэлцээнд аль тал илүү давуу байр суурьтай байгааг ажиглаад 15.4 хувь нь өмгөөлөгчийн байр суурь нь яллагчийнхаас сул байсан гэж дүгнэжээ. Түүнчлэн шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогч хоорондын харилцааг ажиглаж байхад улсын яллагчийн зүгээс шүүгдэгчтэй харилцахдаа илт буруутгах хандлага гарч байснаас гадна шүүгдэгч үйлдсэн хэргийнхээ талаар ярьж байхад шүүгч яриаг тасалдуулах тохиолдол гарч байсан.

Түүнчлэн шүүгдэгч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгааг ажиглахад нийт хэргийн 12.0 хувьд нь л энэ эрхээ хэрэгжүүлжээ. Мөн шүүгдэгч асуултад хариулахаас татгалзах нь өөрийнх нь эсрэг ашиглагдахгүй байх талтайг тайлбарлах явдал хангалтгүй байна. Дийлэнх тохиолдолд шүүгдэгч энэ эрхээ мэдэхгүй өнгөрдөг байна. Тухайлбал, ажиглалтад хамрагдсан нийт хэргийн 22.1 хувьд л энэхүү эрхийг тайлбарлаж өгсөн. Шүүгдэгч өөрийн болон гэр бүлийн гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг ойлгомжтой тайлбарлаж өгөхгүй байгаа нь шүүгдэгч мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулж байна. Тухайлбал, 2015 онд ажигласан нийт хэргийн шүүгдэгч нарын 88 хувь нь дээрх эрхийг эдлээгүй байна.

*Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг шүүх хуралдааны явцад тайлбарласан эсэх (2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулсан байдлаар)*

Хаана	2010 он	2015 он
Хөвсгөл аймаг дахь эрүүгийн анхан шатны шүүх	43.8 %	94.1%
Дорнод аймаг дахь эрүүгийн анхан шатны шүүх	71.4 %	70.4%
Дүүргийн эрүүгийн анхан шатны 1-р шүүх	88.4%	97.1%

Гэм буруугүйд тооцогдох болон Дуугүй байх эрхийн хэрэгжилтийг сайжруулах талаарх Зөвлөмж гаргаж байна:

- Шүүгч шүүгдэгчид өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх болон дуугүй байх эрхийг тайлбарлаж өгөх, өмгөөлөгчдийн зүгээс шүүгдэгчид энэхүү эрхийг сайтар тайлбарлан ойлгуулах мэргэжлийн ёс зүй, үүрэг хариуцлагаа сайтар ухамсарлаж ажиллах;
- Шүүгч, улсын яллагчийн зүгээс шүүгдэгчтэй гэм буруутай мэт буруутган харьцахгүй байх;
- Шүүгдэгчийг аль болох энгийн байдлаар ширээний ард болон дан суудалд суулгах, шоронгийн торыг санагдуулах хашлага зэргийг хэрэглэхгүй байх.

## 5. Шүүх хуралдааныг хойшлуулалгүй явуулах буюу зохимжтой хугацаанд шүүлгэх

Эрүүгийн гэмт хэрэгт татагдсан хүн бүрийн шүүх хуралдаан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлогдох ёсгүй. Тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан байцаан шийтгэх ажиллагааны хугацааг тогтоодог. Яллагдагч тал шүүх хуралдаанд бэлтгэхэд тодорхой хугацаа орох бөгөөд, зохих хэрэгслээр хангагдах ёстой. Байцаан шийтгэх ажиллагаа тодорхой хугацаанд эхэлж, ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр хойшлолгүй эцсийн шатны шүүхийн шийдвэр тодорхой хугацаанд гарах ёстой. Энэ эрх нь эрх бүхий байгууллагуудад шүүн таслах ажиллагааны өмнөх ажиллагаанаас эхлээд эцсийн шатны шүүхийн шийдвэр гарах хугацааг тодорхой байлгах үүрэг хүлээлгэдэг. Ямар ч хүнийг эрүүгийн хэрэгт татан, урьдчилан хорьсон нөхцөлд хэрэг шийдвэрлэлтийг түргэсгэхэд илүү анхаарч ажиллах, ялангуяа яллагдагч хоригдсон нөхцөлд аль болох богино хугацаанд шүүн таслах ажиллагааг явуулах шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа шуурхай явагдах баталгаа нь эрх чөлөөтэй байх, гэм буруугүйд тооцогдох, өөрийгөө хамгаалах эрхүүдтэй холбогддог. Гэрчийн ой санамж арилах буюу мэдээллээ алдах, гэрчүүд шүүх хуралдаанд оролцох боломжгүй болох, бусад нотлох баримт үгүй болох буюу арилах зэргээс сэргийлж, хүний өмгөөлөх эрхийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой хугацаанд байцаан шийтгэх ажиллагааг явуулахыг зорьдог. Хэргээ шуурхай шүүлгэх эрх нь “шударга ёсыг хойшлуулж байгаа нь шударга ёсыг үгүйсгэж байгаатай ижил” хэмээх зүйр үгтэй утга нэг агуулгатай юм.

### **Ажиглалтын дүн**

Шүүгчийн захирамжид дурдсан шүүх хуралдааны товыг хуралдаанд оролцогч бүрт мэдэгдэх, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зуруулах үүргийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээнэ. Гэвч практикт шүүх хуралдаан товлосон цагтаа эхлэхгүй байх, хуралдаан хойшлох тохиолдол байнга давтагдах шинжтэй байна.

*Ажиглалтад хамрагдсан шүүх хуралдааны хойшилсон тухай тоон үзүүлэлт  
(2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулсан байдлаар)*

2010 он		2015 он	
Нийт шүүх хуралдаан	Хойшилсон шүүх хуралдаан	Нийт шүүх хуралдаан	Хойшилсон шүүх хуралдаан
269	76	159	59
28.3%		37.1 %	

Эндээс харахад шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгчийн ачааллыг бууруулах, зохион байгуулалт, захиргааны удирдлагыг сайжруулах чиглэлд багагүй ажил хийгдсэн ч шүүх хуралдаан хойшлох нь түгээмэл, оролцогчид, шүүхээр үйлчлүүлэгч иргэдийн хувьд явдал чирэгдэл учруулсан хэвээр байгааг анхааралдаа авах шаардлагатай.

*Хэнээс болж шүүх хуралдаан хойшилсныг оролцогчдоор харуулсан үзүүлэлт  
(2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулснаар)*

Ажиглалт	Шүүгч	Улсын ялагч	Өмгөөлөгч	Бусад оролцогч
2010 онд	5.6%	19.4%	44.4%	30.6%
2015 онд	3.3%	22.9%	52.5%	21.3%

Өмгөөлөгчөөс шалтгаалан шүүх хуралдаан хойшлох явдал маш өндөр хувьтай байгаа бөгөөд хойшлуулж байгаа шалтгааныг доорх байдлаар баримтжуулжээ. Үүнд:

Тодорхойгүй	9
Томилолттой	6
Цаг тухайд нь мэдэгдээгүй	4
Өвчтэй	4
Хурал давхардсан	3
Ар гэрт нь ажил гарсан	2
Өмгөөлөгч нэмж авах хүсэлт гаргасан	1
Шинжээч оролцуулах хүсэлт гаргасан	1
Гэрч оролцуулах хүсэлт гаргасан	1
Шүүгдэгчийн өмгөөлөгч солигдсон	1

*Шүүх хуралдаан хойшилсныг шүүхүүдийн байршлаар харьцуулсан үзүүлэлт  
(2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулснаар)*

Ажиглалт	УБ	Дорнод	Төв	Хөвсгөл
2010 онд	24%	20%	-	39.1%
2015 онд	41.6% (60-25)	12.9% (31-4)	43.3% (30-11)	52.6% (38-19)

Шүүх хуралдаан хойшлох явдал эрүүгийн хурлын хувьд 9 хувиар нэмэгдэж гарсан нь зайлшгүй анхаарах ёстой асуудал бөгөөд учир шалтгааныг лавлан тодруулахад шүүгчээс болон бусад оролцогчоос шалтгаалсан тохиолдол буурсан байхад улсын ялагч, өмгөөлөгчөөс шалтгаалсан нь их байгаа ба энэ чиглэлээр асуудал дэвшүүлэн зохих талууд хамтран ажиллах шаардлагатайг харуулж байна. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хурал хойшлуулах хүсэлтийг урьдчилан

мэдэгдэж бусад оролцогч болон шүүхийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахаас сэргийлэх боломжтой байдаг боловч дийлэнх тохиолдолд уг хүсэлтийг шүүх хуралдаан нээсний дараа гэнэт гаргаж тавьдаг буруу практик хэвшил болжээ. Түүнчлэн ажиглалт хийсэн шүүх хуралдааны 41 (25.8 хувь) нь урьд өмнө хойшилсон хуралдаан байгаа нь хурал хойшилж байгаа учир шалтгааныг нарийн тогтоож, зохион байгуулалт, харилцаа холбооны шинэ систем бий болгох хэрэгтэйг харуулж байна. Мөн товлосон шүүх хуралдаан цагтаа эхлэх нь ховор бөгөөд ажигласан шүүх хурлуудын 85.5 хувь нь 10-30 минут, 10.1 хувь нь 31 минутаас 1 цаг 30 минут хүртэл хугацаагаар хоцорч эхэлжээ. Мөн хурал даргалагч шүүгч өөр хурлын шүүх бүрэлдэхүүнд орсон тул хуралдаан цагаас хоцрох тохиолдол ч гарсан.

Шүүх хурал хойшилсныг хэн ч мэдээгүй ба шүүгч болон хурлын нарийн бичгийн даргаас бусад бүх оролцогч ирсэн байв. Гэтэл өөр хурлын нарийн бичгийн дарга 09:30-д тус танхимд орж ирээд микрофон шалгаж байхаар нь “Энэ шүүх хурал хойшилж байгаа юм уу” гэж асуухад “Шүүгч нь ирээгүй юм бол хойшилж байгаа юм байлгүй дээ” гэж хариулав.

Шүүгдэгчийн 1 өмгөөлөгчийн шүүх хурал давхацсан. Нөгөө өмгөөлөгч нь тодорхойгүй шалтгаанаар шүүх хуралд ирээгүй учир хурал хойшилсон. Шүүгдэгч шүүх хуралд ирэхдээ согтуу байсан. Энэ нь шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэж байна. Энэ шүүх хурал нийтдээ 4 удаа хойшлов.

Шүүгдэгч УБ хотын 416-р ангид хоригдож байгаа, Тахарын алба нь хүнээ авчраагүй. Өөр ажилд явсан тул цагтаа ирж амжихгүй гэсэн шалтгаанаар хурлын цагийг хойшлуулсан.

Шүүх хуралдааны тов гаргах, түүнийгээ иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээлэх асуудал хөдөө орон нутагт учир дутагдалтай байгаа нь ажиглагдлаа. Үүнд:

- Шүүх хуралдааны товыг долоо хоног бүрээр нийтэд ил гаргаж тавьдаггүй;
- Товыг нийтэд ил болгосон ч хангалттай хугацааны өмнө гаргадаггүй;
- Нийтэд ил болгосон хуваарьт шүүх хуралдааны оролцогчдын мэдээлэл, хуралдаан нээлттэй зарлагдсан эсэх, шүүх хуралдааны танхимын мэдээлэл оруулдаггүй зэрэг дутагдал ажиглагдсан болно.

Шүүх хуралдааныг хойшлуулахгүй, цаг тухайд нь хийх тухайд энэ удаагийн ажиглалтаас дараах Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Шүүх хуралдаан хойшлох нь шударга шүүхээр цаг алдалгүй шүүлгэж гэм буруугаа тогтоолгох буюу хохирлоо барагдуулах иргэний эрхийг зөрчиж

- буй хэрэг юм. Тиймээс шүүх ажиллагааны оролцогч тус бүр энэ асуудалд анхааралтай хандаж шүүх хуралдааныг аль болох бодитой товлох, хурлын тов өөрчлөгдсөн тохиолдолд цаг алдалгүй мэдэгдэж зохих зохицуулалтыг хийх талаар холбогдох байгууллагууд анхаарах;
2. Өмгөөлөгч болон улсын яллагчид хэд хэдэн хэрэг дээр ажиллах тохиолдолд тэдний оролцох хурлын товыг давхардуулахгүй байх үүднээс шүүхүүдийн тамгын газар хоорондын цахим бүртгэл, мэдээллийн системээр дамжуулан хуульчдын оролцохоор товлогдсон хурлуудын давхардлыг арилгаж, өдөр цагийг зөрүүлэн товлох техникийн шийдлийг бий болгох;
  3. Шүүхийн зүгээс тодорхой шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй субъектэд мэргэжлийн хариуцлага тооцох, шүүхийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах чиглэлээр Хуульчдын холбоотой хамтран ажиллах;
  4. Шүүх хуралдааны талууд нэгээс илүү өмгөөлөгчтэй тохиолдолд аль нэг өмгөөлөгч ирээгүйгээс үүдэн шүүх хурал хойшилдог явдлыг процессын хуулиар таслан зогсоох зохицуулалт хийх;
  5. Шүүх хуралдааны тов гаргах, нийтэд мэдээлэх нэгдсэн стандарт гаргаж мөрдүүлэх. Үүнд: хурлын оролцогчдын тухай болон шүүх хуралдааны танхим, хэргийн зүйлчлэл, нээлттэй хаалттай эсэх тухай аль болох дэлгэрэнгүй мэдээллийг оруулж өгөх хэрэгтэй. Шүүх хуралдааны товыг хангалттай хугацааны өмнө буюу одоогийн мөрдөж байгаа хурал болохоос өмнөх 7 хоногийн Пүрэв гаригт нийтэд ил болгох шаардлагыг бүх шүүхэд хэвшүүлэх шаардлагатай.

## 6. Өөрөө өөрийгөө буюу өмгөөлөгчөөр дамжуулан өмгөөлөх<sup>12</sup> эрхийн хэрэгжилт

Эрүүгийн хэрэгт татагдсан хүн бүр өөрөө өөрийгөө буюу өмгөөлөгчөөр дамжуулан өмгөөлөх эрхтэй. Тэд өөрсдөө өмгөөлөгчөө сонгож, төлбөр төлж хууль зүйн туслалцаа авч чадахгүй бол талуудын тэгш байдлыг хангах үүднээс төрөөс томилсон мэргэжлийн өмгөөлөгчөөс тусламж авах эрхтэй. Энэхүү эрхийг эдлэхдээ дараах шаардлагыг хангахад эрх бүхий байгууллагууд анхаарах ёстой байдаг. Үүнд:

- Энэ эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд шүүн таслах ажиллагаа явагдахаас өмнө өмгөөлөх ажиллагаанд зориулж тодорхой хугацааны өмнө мэдэгдсэн байх ёстой.
- Өмгөөлөгч болон шүүгдэгчийн хооронд харилцан итгэлцэл бүрдүүлэх үүднээс шүүгдэгч ямар өмгөөлөгч авахаа өөрөө шийдэх эрхтэй.

12 МУ-ын Үндсэн хуулийн 16. 4-р зүйл МУ-ын, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 18-р зүйл

- Яллагдагч болон өмгөөлөгч нарын хоорондын харилцаа нь нууцлалтай байна.
- Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ эрх, эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүхий л боломжит гарцыг тайлбарлаж, шүүх дээр эрхийг нь хамгаалахад туслах үүрэгтэй. Эрх бүхий байгууллагаас яллагдагчид өмгөөлөгч томилж өгөхдөө тухайн холбогдох асуудлаар уг өмгөөлөгч тодорхой туршлага, мэдлэгтэй эсэхийг харгалзан үзэх ёстой.
- Өмгөөлөгчдийг айлган сүрдүүлэх буюу мэргэжлийнхээ дагуу ажиллаж буй өмгөөлөгчийн үйл хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглодог.

### **Ажиглалтын дүн**

Ажигласан шүүх хуралдааны 83.1 хувьд шүүгдэгчийн өмгөөлөгч, 31 хувьд нь хохирогчийн өмгөөлөгч оролцжээ. 2010 оны ажиглалтаар шүүгдэгчийн өмгөөлөгчийн оролцоо 93.6 хувь, хохирогчийн өмгөөлөгчийн оролцоо 18.9 хувь гэж гарч байжээ.

Энэ удаагийн ажигласан хуралдааны 23.5 хувьд төрөөс томилогдсон улсын өмгөөлөгч шүүгдэгчийг төлөөлж ажилласан нь 2010 оны үзүүлэлтээс (15.9%) нэмэгдсэн дүн гарчээ. Энэ нь төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх Хууль зүйн туслалцааны төвүүд, улсын өмгөөлөгчид ажиллаж эхэлсэнтэй холбоотой гэж үзэж байна.

#### *Өмгөөлөгчийн оролцооны талаарх ажиглалтын дүн*

Асуултууд	2015 он
Шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх боломжийг нь хаасан, хязгаарласан ямар нэг саад бэрхшээл ажиглагдсан уу?	Тийм (2 %)
Шүүх хурлын үеэр өмгөөлөгч шүүгдэгчтэй харилцах боломжийг тодорхойлно уу?	Харилцан ярилцах боломжгүй байсан (14.3 %)
Шүүгдэгч мэргэжлийн, чанартай, үр дүнтэй өмгөөллөөр хангагдаж чадсан уу?	Тийм (87 %)
Хохирогч мэргэжлийн, чанартай, үр дүнтэй өмгөөллөөр хангагдаж чадсан уу?	Тийм (52.8 %)

Шүүх хуралдааны үед шүүгдэгчийн өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчтэйгээ хэрхэн харьцаж байгаа талаар судлахад: 94.5 хувь нь хэвийн 3.3 хувь нь хүйтэн, дээрэнгүй, 2.2 хувь нь үл тоомсорлосон байдалтай харьцаж байсныг тодорхойлжээ. Ийнхүү өмгөөлөгчийн харилцааны сул талыг илэрхийлсэн үзүүлэлт бага хувийг эзэлж байгаа боловч өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн үүднээс авч үзэхэд энэ нь байж боломгүй дүн гарчээ. Түүнчлэн шүүгдэгч шүүх



хуралдааны үед өмгөөлөгчийнхөө туслалцааг бүрэн авах боломж нөхцөлийг тодорхойлоход: 83.3 хувь нь зэрэгцэж суусан тул харилцан ярилцах нь боломжтой, 14.3 хувь нь харилцан ярилцах боломж нь хязгаарлагдмал, 2.4 хувь нь хурал даргалагчаас хурлын дэгд захирагдахыг шаардаж байсныг тэмдэглэжээ. Мөн ажиглагчдын үнэлгээгээр нийт хуралд оролцсон шүүгдэгчийн 13.0 хувь нь чанартай төвшинд өмгөөллийн туслалцаа авч чадаагүй бол хохирогчдын 47.2 хувь нь дээрх шаардлага хангасан өмгөөллийн үйлчилгээ авч чадаагүй ажээ.

Өмгөөлөгчдөөс шалтгаалан хурал хойшлох явдал маш өндөр хувьтай гарсан бөгөөд үүнээс 9 удаад нь ирээгүй шалтгаанаа тодорхой мэдэгдээгүйгээс шүүх хуралдаан хойшилсон гэж байв. Энэ нь шүүхийг үл хүндэтгэсэн, хуульчийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагад харшилсан үйлдэл юм. Гэвч ажиглалтын явцад шүүхийн нарийн бичгийн даргын зүгээс өмгөөлөгчийн ирээгүй шалтгааныг оролцогчдод мэдэгдээгүйгээс ажиглагчид арга зүйн хувьд зөвхөн шүүх танхимаас олж авсан мэдээлэлд суурилж дүгнэлт гаргах удирдамжийн дагуу ажилласан тул энэ үзүүлэлт өндөр гарсан байх магадлалтай болохыг энд тодотгохыг хүсэж байна.

Ажиглалтын дүнд үндэслэн өмгөөллийн эрхтэй холбогдсон асуудлаар дараах Зөвлөмжийг гаргаж байна:

1. Өмгөөлөгчид улсын яллагчтай эрх тэгш байдлаар шүүх хуралдаанд оролцох боломжийг хууль эрх үйн хүрээнд олгох;
2. Өмгөөлөгчид шүүгдэгчид чанартай хууль зүйн туслалцаа, өмгөөлөл үзүүлэхэд бэлтгэх хангалттай хугацаа олгодог болох;
3. Төлбөрийн чадваргүй шүүгдэгчид өмгөөлөгч томилж байгааг сайшаахын зэрэгцээ тэдний ур чадварыг дээшлүүлэхэд холбогдох эрх бүхий байгууллагаас анхаарч, үйлчилгээний чанарыг хянах;
4. Хуульчдын Холбооны зүгээс өмгөөлөгчдийн мэргэжлийн хариуцлага, үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой алхам хийх;
5. Шүүхээс өмгөөлөгчдийн оролцоо, мэргэжлийн хариуцлага, ёс зүйтэй холбоотой асуудлаар Хуульчдын холбоотой хамтран ажиллаж сахилгын төвшинд асуудлыг тавьж шийддэг болох;

## 7. Гэрчийг дуудах ба шалгах эрхийн<sup>13</sup> хэрэгжилт

Эрүүгийн хэрэгт холбогдсон хүн бүхэн өөрийн талд гэрч дуудах болон өөрийн эсрэг гэрчийг шалгах, шалгуулах эрхтэй. Байцаан шийтгэх ажиллагааны талуудын

---

13 МУ-ын Үндсэн хуулийн 16.14-р зүйл

тэгш байдлын зарчим ба өмгөөллийн эрхийн үндсэн элемент нь шүүгдэгчийн гэрчийг дуудах ба шалгах эрх юм. Гэрчийг дуудах ба шалгах эрх нь өмгөөлөгчид шүүгдэгчийн талд мэдүүлэг өгөх гэрчийг асуух болон шүүгдэгчийн эсрэг нотолгоонд няцаалт хийх боломжийг олгоно.

### **Ажиглалтын дүн**

Шүүхийн мэтгэлцээнийг амжилттай явуулах нэг үндэслэл нь шүүх хуралдаанд яллах, өмгөөлөх талууд гэрч оролцуулах тэгш боломжоор хангагдсан байх явдал. Гэвч амьдрал дээр оролцоо туйлын хангалтгүй дүнтэй ажиглагдлаа. Ажиглалтын явцад нийт 159 хэрэг хянан хэлэлцсэний 5.3 хувьд яллах талын гэрч оролцсон бол өмгөөлөх талын гэрч 4.2 хувьд нь л байв. Эндээс харахад талууд хуулиар олгогдсон бүрэн эрх боломжоо хангалтгүй ашиглаж байна. Түүнчлэн шүүх хуралдаанд дуудагдан ирсэн гэрчид эрхийг нь тайлбарлахдаа хойрго хандах тохиолдол гарч байв.

Судалгааны нэгтгэсэн дүнгээс үзэхэд гэрчийн эрхийг тайлбарлахгүй орхигдуулах, хагас дутуу тайлбарласан зөрчил 20 хувийг эзэлж байна. Харин гэрчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг 100 хувь тайлбарлажээ.

Шүүх хуралдаанд оролцогчдын зүгээс гэрчид сэтгэл зүйн болон бусад дарамт үзүүлсэн эсэхийг судлахад 12.5 хувь “тийм” гэж хариулжээ. Түүнчлэн шүүхийн хэлэлцүүлэгт гаргаж өгсөн гэрчийн мэдүүлэг мөрдөн байцаалт өгсөн мэдүүлгээс зөрсөн тохиолдол 26.1 хувьтай байна.

2010 онд ажигласан нийт шүүх хурлын 18.1 хувьд яллах талын гэрч, 3.2 хувьд цагаатгах талын гэрч оролцсон дүн мэдээ гарч байсан. Үүнээс дүгнэхэд гэрчийн оролцоо бүхэлдээ багассан ч цагаатгах талын гэрч илүү оролцох чиг хандлага байгааг дурдах нь зүйтэй.

Шинжээчийн хувьд нийт 5 шүүх хуралдаанд оролцсон бөгөөд хоёр удаад нь л түүний эрх үүргийг тайлбарлаж өгсөн байна. Эрх үүргийн хүрээнд шүүгдэгчид шинжээчийг татгалзан гаргах эрх байгааг мөн 2 удаад нь тайлбарлаж өгчээ. Шүүх хуралдааны үед шинжээчийн дүгнэлтийг хэлэлцсэний дараа талууд нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх хүсэлтийг 13.3 хувь нь гаргасан байна.

Гэрчийг дуудах ба шалгах эрхийн хэрэгжилтийн хүрээний Зөвлөмж:

- Шүүхийн мэтгэлцээний бодит үр дүнг дээшлүүлэхийн тулд яллах, өмгөөлөх талуудаас гэрч дуудан оролцуулах эрхээ эдлэх боломжоор хангах;
- Гэрчид ямар нэгэн байдлаар дарамт үзүүлэх явдлыг таслан зогсоох, гэрч хохирогчийг хамгаалах эрх бүхий байгууллага нь шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг эрхлэн явуулах;

- Шүүгчийн зүгээс гэрчийг аливаа байдлаар талуудын дарамт шахалтад орсон эсэх талаар хуулийн хүрээнд шалгах, гэрчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар анхаарч ажиллах;
- Шүүх хуралдаанд шинжээчийг биечлэн оролцуулахад шүүхийн зүгээс идэвх санаачилга гарган ажиллах шаардлагатай.

## 8. Хэлмэрч ба орчуулгын үйлчилгээ авах эрхийн<sup>14</sup> хэрэгжилт

Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон хүн шүүхэд хэрэглэгдэх хэлийг ойлгохгүй ба ярьж чадахгүй тохиолдолд мэргэшсэн орчуулагч, хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүйгээр авах эрхтэй байдаг. Тэдэнд бичиг баримтаа орчуулуулах эрх ч бас бий. Шүүгдэгч шүүхээс хэрэглэгдэж буй хэлээр ярих, ойлгох эсвэл унших бэрхшээлтэй тулгарахад хэлмэрчийн болон орчуулгын үйлчилгээ авах эрх нь байцаан шийтгэх ажиллагааг шударга явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Орчуулагч, хэлмэрчийн туслалцаа авах эрх нь шүүгдэгч болж буй байцаан шийтгэх үйл явцыг сайтар ойлгож, чанартай өмгөөллийн үйлчилгээ авахад шууд нөлөөтэй. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч шүүхээс хэрэглэж буй хэлийг мэдэхгүй, эсвэл ойлгоход бэрхшээлтэй байх нь өмгөөллийн эрхэд томоохон саад тотгор учруулж болзошгүй. Энэхүү эрх нь мөрдөн байцаах ажиллагаа болон урьдчилсан байцаалт оролцуулан бүх шатны эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хамаардаг.

### **Ажиглалтын дүн**

ЭБШХ-ийн 256.1-д зааснаар орчуулагч, хэлмэрч нь шүүх хуралдааны монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий оролцогчийн мэдүүлэг, хүсэлтийг бусад оролцогчдод, шүүх хуралдаанд хэлэлцэгдэж байгаа асуудлыг тухайн оролцогчид гэх зэргээр харилцан ойлголцлыг хангаж орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй байдаг. Шүүгч орчуулагч, хэлмэрч авах шаардлагатай оролцогчид энэ эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.

Шүүх хуралдааны ажиглалтын явцад оролцогчдын эрх, үүрэг тэдгээрийн тавьсан хүсэлт хэрхэн хангагдаж байгааг тусгайлан авч үзсэн болно. Тухайлбал, шүүгдэгч орчуулагч, хэлмэрч авах тухай хүсэлт гаргасан эсэхийг ажиглахад нийт шүүх хуралдааны 4 хувьд нь энэ тухай хүсэлт гаргажээ. Мөн сэтгэцийн өөрчлөлттэй, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй шүүгдэгчид<sup>15</sup> хэлмэрч авах эрхийг нь

<sup>14</sup> МУ-ын Үндсэн хуулийн 16.14-р зүйл, МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 19 -р зүйл

<sup>15</sup> Дорнод аймагт сонсголын илт бэрхшээлтэй шүүгдэгчид хэлмэрч гаргаж өгөөгүй тохиолдолд тэмдэглэгдсэн.

сануулах, шүүхэд эрхээ хамгаалуулахад ямар нэг туслалцаагүйгээр шүүх хурал явагдаж өнгөрсөн тохиолдол гарсан нь шударгаар шүүлгэх эрхийн ноцтой зөрчил юм. Шүүгдэгчийн эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдлыг тодорхойлох, эрх зүйн чадамжийн асуудлыг сайтар нягталж үзэх шаардлагатай байна.

Хэлмэрч ба орчуулгын үйлчилгээ авах эрхийн асуудлаар дараах Зөвлөмж гаргаж байна:

1. ЭБШХ-ийн 256 дугаар зүйлийн 256.1-д заасны дагуу шаардлагатай тохиолдолд шүүх хуралдаанд гадаад хэлний орчуулагч, дохионы хэлний хэлмэрч оролцуулж байх;
2. Оролцогчид шүүхэд хэрэг хянан хэлэлцэж байгаа үйл явцыг бүрэн ойлгож байгаа эсэхийг лавлаж баталгаажуулах нь иргэний шударгаар шүүлгэх эрхийн нэн чухал баталгаа гэдгийг санаж энэ бололцоог хангахад шаардлагатай хүчин чармайлт гаргах нь зүйтэй.

## 9. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй, хууль ёсны байх стандартын хэрэгжилт

Шүүхийн шийдвэр нь шүүх хурал хаалттай явагдсан эсэхээс үл хамааран нийтэд нээлттэй байх ёстой. Шүүхээр шүүлгэж буй хүн бүр шийдвэрийн үндэслэлтэй танилцах болон зөвхөн байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон шүүгчээр шүүлгэх эрхтэй. Шүүхээр ил тод шийдвэрлүүлэх эрхийн гол зорилго нь шударга ёсны хэрэгжилт ил тод байж олон нийтийн зүгээс хяналт тавих боломж олгоход оршдог. Шүүхийн шийдвэр нь шүүх хуралдааны үеэр амаар танилцуулагдсан, эсвэл бичгээр хэвлэгдсэн бол ил тод үйлдэгдсэнд тооцогдоно. Хэрэв зөвхөн хэсэг бүлэг хүмүүст хүртээлтэй үйлдэгдсэн, эсвэл зөвхөн тодорхой ашиг сонирхол бүхий хүмүүст шалгахыг зөвшөөрсөн бол нээлттэй шийдвэрлүүлэх эрх зөрчигдсэн гэж үзнэ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь шүүгдэгчийн давж заалдах эрхийн гол үндэс болдог. Тиймээс, шүүхийн шийдвэр нь шүүх хурлын үеэр хэлэлцэгдсэн хэргийн бодит байдал, түүнийг дэмжих хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн гарах бөгөөд үүнийг шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал гэж ойлгоно.

### **Ажиглалтын дүн**

Шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, нэмэлт өөрчлөлт оруулах талаар оролцогчдод тайлбарлаж өгөх нь чухал ач холбогдолтой боловч нийт ажиглалтад хамрагдсан 97 хэргийн 36.5 хувьд нь энэ эрхийг тайлбарлаж өгөөгүй байна. Шүүхийн шийдвэрийн агуулгыг авч үзвэл:

– Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон	41.2%
– Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч тэнссэн	37.1%
– Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан	9.3%
– Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч ялыг хойшлуулсан	4.1%
– Хэргийг хэрэгсэхгүй болгосон	4.1%
– Шүүгдэгчийг цагаатгасан	1%
– Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу өршөөн хэлтрүүлсэн	1%
– Хэргийг прокурорт буцаасан	1%
– Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах	1%

Шүүхийн шийдвэрийг ажиглагчид дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

– Хангалттай нотлох баримтад тулгуурлаагүй	10%
– Хэргийн нөхцөл байдлыг хагас дутуу үнэлсэн	22.5%
– Бодит фактад тулгуурлаагүй	8.2%
– Талуудад тэгш боломж олгоогүй	8.6%
– Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг уншиж сонсгоогүй	56.5%
– Шүүхийн тогтоолыг уншиж сонсгосны дараа давж заалдах эрхийг тайлбарлах үүргээ биелүүлээгүй	1.1%

Анхан шатны эрүүгийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцох нь шүүхээс шударга шийдвэр гаргах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх ач холбогдолтой. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн гаргасан саналыг тоймлон авч үзэхэд, нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх, нотлох баримтаар тогтоогдоогүй, хэргийг эцэслэн шийдвэрлэхэд эргэлзээтэй, шүүгдэгч хийсэн хэрэгтээ гэмшихгүй байх гэх мэтээр ерөнхийдөө улсын яллагчийн оноосон ялыг дэмжих хандлагатай байна.

Шүүхийн шийдвэр үндэслэлтэй, хууль ёсны байх стандартын хэрэгжилттэй холбогдуулж дараах Зөвлөмж гаргав:

- Шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах түүнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг хуралдааны эхэнд ойлгомжтой тайлбарлах;
- Шүүхийн шийдвэр хууль ёсны үндэслэлтэй байх шаардлагыг хэрэг нэг бүр дээр хангахын тулд нотлох баримтыг шүүхийн хэлэлцүүлгийн явцад шүүх хуралдааны бусад оролцогчдод ойлгомжтой танилцуулж хэлэлцүүлдэг байх;
- Шүүх хуралдааны үе шатыг алгасахгүй байх буюу зарим баримт нотолгоог уншиж танилцуулахгүй өнгөрүүлдэг явдлыг шүүх хуралдаан даргалагч таслан зогсоох;

- Шүүхийн шийдвэрийг шүүхэд хэлэлцэгдсэн нотлох баримт, талуудын тэгш оролцоо, мэтгэлцээнд суурилан үндэслэлтэй гаргах;
- Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг танхимд уншиж сонсгох үе шатыг алгасахгүй байх;
- Анхан шатны шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн эрх, үүргийг таниулах сургалт зохион байгуулах буюу тэдэнд зориулсан шаардлагатай сургалтын мэдээлэл боловсруулж өргөнөөр түгээх нь зүйтэй.

## Б. Шүүх хуралдааны зарим онцгой субъектүүдийн оролцоо

Шүүхийн ажиглалтаар шүүх хуралдааны оролцогч зарим онцгой субъект болох хохирогч, шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны хэвийн ажиллагааг хангах үүрэг бүхий үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа шүүхийн захиргааны ажилтан, шүүхийн тахар нарын оролцоо, биеэ авч яваа байдал зэргийг авч үзлээ. Дараах дүгнэлт зөвлөмж нь төслийн явцад бүрэн ажигласан 97 шүүх хурлын мэдээлэлд үндэслэсэн болно.

### **Хохирогч**

ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1-д “гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ.” хэмээн тодорхойлж, мөн зүйлийн 42.3-т хохирогч, түүний төлөөлөгч нь өмгөөлөгч авах, баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, шүүх хуралдаанд оролцох, шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй болохыг заасан байна.

Нийт ажигласан хурлын 37 хувьд хохирогч оролцсон нь өмнөх ажиглалтын 44.8 хувьтай харьцуулахад буурсан дүн байна. Мөн нийт хурлын 19.5 хувьд хохирогчийн өмгөөлөгч оролцсон нь өмнөх ажиглалтын 25.3 хувьтай харьцуулахад мөн буурсан үзүүлэлт гарчээ. Үүнээс харахад хохирогчид шүүх хуралдаанд оролцох сонирхол хүсэлгүй, эс бөгөөс боломжгүй байгаа нь харагдаж байна.

### ***Шүүхийн иргэдийн төлөөлөгч***

Шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа, тодорхой шалгуур хангаж сонгогдсон иргэдийг “шүүхийн иргэдийн төлөөлөгч” гэх бөгөөд тэднийг сонгох, шүүх хуралдаанд оролцуулах үйл явц, тэдний эдлэх эрх, хүлээх хариуцлагын талаар зохицуулсан бие даасан хууль 2012 онд Шүүхийн тухай багц хуулийн хүрээнд батлагдан гарсан. Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, оролцооны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан боловч бүрэн утгаараа хэрэгжихгүй байгааг дурдах нь зүйтэй.

Процессын хувьд ЭБШХ-ийн 4 дүгээр зүйлийн 34.1-д “иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих эрхтэй бөгөөд нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах эрхтэй. Иргэдийн төлөөлөгч саналаа шүүх хуралдаанд уншиж сонгож болно”, 34.2-т “шүүх анхан шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэхэд 3 иргэдийн төлөөлөгчийг оролцуулна”, мөн хуулийн 261 дүгээр зүйлийн 261.3-т “шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэхэд оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй” гэж тус тус заасан байдаг.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 7.1.8.-р зүйлд шүүхийн тамгын газрын үүргийг “шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, лавлагаагаар хангах, аливаа нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн төлөөлөгчийн хориглосон үйлдэлд хяналт тавих, үйлдэл гарсан тохиолдолд холбогдох байгууллагад хандах” гэж заажээ.

Нийт бүрэн ажигласан 97 шүүх хуралдааны 20.6 хувьд буюу 20 шүүх хуралдаан нь шүүх бүрэлдэхүүнтэй явагдсан тул иргэдийн төлөөлөгч оролцсон байна. Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийг хэрхэн сонгож оролцуулж байгаа нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчдийн тоо ялгаатай (1-3), нэрс байнгын тогтмол давтамжтай, нэрийн жагсаалтад өөрчлөлт орохгүй байгаа буюу шинээр батлагдсан Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 8, 9-р зүйл хэрэгжихгүй байна. Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийн тоо харилцан адилгүй байгаа нь эрх зүйн ямар үр дагавартай болох, ямар шалгуураар оролцох иргэдийн төлөөлөгчийн тоог тогтоож байгаа нь тодорхойгүй байна.



Иргэдийн төлөөлөгчийн оролцоотой 20 шүүх хуралдааны 9-д (45 хувь) тэдний дүгнэлтийг уншиж сонгосон. Эдгээр дүгнэлтийн ихэнх нь үндэслэл сайтай байсан бөгөөд шүүх бүрэлдэхүүнийг шийдвэрээ гаргахдаа нотлох баримтад үндэслэх, хөнгөрүүлэх нөхцөлийг сайтар харгалзаж үзэхийг сануулах, шүүгдэгчийн гэм буруу нь нотлох баримтаар тогтоогдохгүй байна гэж үзсэн гэх зэрэг зарчмын шинжтэй санал, дүгнэлт өгч байжээ.

2010 оны байдалтай харьцуулахад иргэдийн төлөөлөгчдийн оролцооны чанар дээшилсэн байдалтай байгаа нь сайшаалтай.

### ***Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга***

2012 онд батлагдсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 25.1-т “Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан байна” гэж заагаад Монгол Улсын иргэн байх, Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх, ял шийтгэлгүй байх, энэ хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх, тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх гэсэн шалгуурыг хангасан байхаар хуульчилж өгчээ. Дээрх хуулийн 29-р зүйлд шүүхийн захиргааны ажилтны ёс зүйг зааж оруулсан нь хуулийн нэгэн дэвшилттэй тал юм. Үүнд шүүхийн захиргааны ажилтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрэм, хэм хэмжээг мөрдөхөөс гадна ёс зүйн дараах ерөнхий шаардлагыг биелүүлж ажиллана:

- шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны талаар тухайн хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд аливаа зөвлөгөө, мэдээлэл өгөхгүй, аливаа хэлбэрээр бусдад зуучлахгүй байх;
- шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар хувийн таамаглал, урьдчилсан дүгнэлтээ бусдад илэрхийлэхгүй байх;
- хэргийн оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх;
- ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй байдал гаргахгүй байх;
- шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагад ажиллаж байгаадаа хүндэтгэлтэй хандаж, ажлын байр, олон нийтийн дунд биеэ зөв авч явах.

Шүүхийн нарийн бичгийн дарга нь шүүхийн үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг болох шүүх хуралдаан явуулах байр, танхим, техникийн бэлтгэл хангах, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүх хуралдааны ирцийг бүртгэн, ирээгүй



этгээдэд мэдэгдэх хуудас хүргүүлсэн эсэх, ирээгүй бол шалтгааныг хуралдаан даргалагчид танилцуулах зэрэг үндсэн чиг үүрэг хүлээн шүүх хуралдааны ажиглагч, иргэд олон нийтэд шүүхийн захиргааны үйл ажиллагааг хариуцан ажиллаж, үйлчилгээг хүргэх чухал субъект юм.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нийт ажиглагдсан хурлын тавд буюу 5.1 хувьд шаардлагатай техник хэрэгслийг хуралдаан эхлэхээс өмнө бэлэн болгоогүй байсан бөгөөд нийт бүрэн ажигласан хурлын зургаад буюу 6.2 хувьд видео бичлэг хийгдээгүй хэмээн тэмдэглэгджээ. Аудио бичлэг хийгдэж байсан эсэхийг ажиглалтын явцад баримтжуулах боломжгүй байлаа. 7.2 хувьд шүүх хуралдаан эхлэхэд бүх оролцогч зохих байраа эзлээгүй байсан бөгөөд энэ нь шүүх хуралдааны нарийн бичгийн дарга заавар удирдамж өгөх зохион байгуулалтын ажлаа хийгээгүйтэй холбоотой гэж үзэж байна. Мөн нийт хурлын 4.1 хувьд нарийн бичгийн дарга нь албаны бус хувцаслалттай байсан гэдгийг дурджээ. Орон нутгийн төвшинд нарийн бичгийн даргын харилцааг энгийн эелдэг гэсэн бол дүүргийн шүүхийн нарийн бичгийн дарга нарын дунд харилцааны хувьд бүдүүлэг дээрэнгүй харилцах тохиолдол гарч байсныг дурдах нь зүйтэй.

2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулахад шүүх хуралдааныг тэмдэглэх зэрэгт техникийн хувьд ахиц гарсан хэдий ч шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар шүүх хуралдааны техникийн бэлтгэлийг бүрэн хангах, иргэд, шүүх хуралдааны оролцогчидтой харилцах, тал дээр учир дутагдалтай байдал ажиглагдлаа.

Шүүхийн ажилтан танхимаас гарахыг шаардаж загнаж байсан. Дадлагын оюутнууд шинээр авсан микрофон эвдчихнэ гэх шалтгаанаар танхимаас хөөсөн. Бүдүүлэг дээрэнгүй харьцаж орилж, хашхичиж Зайл гэж хөөсөн

### **Шүүхийн тахар**

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг 2014 оны 1 сарын 1-ээс эхлэн Тахарын Ерөнхий Газар хариуцан хэрэгжүүлэх болсон. Тахарын албаны хуульд заасны дагуу шүүх хуралдааны явцад шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар Тахарын алба дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэжээ. Үүнд:

- шүүхийн харуул хамгаалалтыг хэрэгжүүлэх, шүүх хуралдааны журам сахиулах;
- шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах;

- яллагдагчийг хуяглан хүргэх;
- шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх зэрэг хамаарна.

Шүүхийн танхимд журам сахиулах тахарын ажилтны оролцоо ерөнхийдөө хангалттай байгаа боловч зарим тохиолдолд шүүх хуралдаан дуусахаас өмнө танхимыг орхин гарах тохиолдол гарчээ.

Хурал эхлэхэд Тахар байгаагүй дундуур нь нэг орж ирсэн. Эргэж гараад орж ирээгүй.

Шүүх хуралдааны танхимд дэг зөрчигдсөн тохиолдолд шүүгчийн зүгээс зохих арга хэмжээ авахыг хуулиар зохицуулсан байдаг. Үүнд сануулах, зөрчил гаргагчийг танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авч байсан боловч шүүх хуралдааны оролцогчид удаа дараагийн сануулгыг үл ойшоох, давтан зөрчил гаргах зэрэг дутагдал ажиглагдсан байна.

Хохирогчийн өмгөөлөгч шүүх хурал эхэлсэн хойно орохыг завдсан тул шүүгч өмгөөлөгчийг хуралд орж болохгүйг сануулаад, цагдаагаар танхимаас гаргуулсан.

Хоёр залуу хурал эхэлсэн хойно орж ирэхэд шүүгч "хурал албан ёсоор эхэлсэн байна та 2 юун улсууд вэ" гэхэд бид 2 хохирогчид гээд шууд л ширээний ард суусан. Ямар нэг арга хэмжээ аваагүй.

Хөвсгөл аймагт шүүх хуралдааны дэгийг цагдаа сахиулдаг хэвээр байсан ба 2014 оны 12 дугаар сарын 30-аас эхэлж шүүх хуралдаанд тахар оролцох болсон.

Шүүхийн тахарын харилцааны хувьд ерөнхийдөө энгийн гэж дүгнэгдсэн байна. Шүүх болон шүүх хуралдааны нээлттэй байдлыг хэрхэн хангах талаарх нийтлэг ойлголт харуул тахаруудад байхгүй байгаа нь ажиглагдсан бөгөөд иргэдэд мэдээлэл өгөх чиг үүрэг давхар гүйцэтгэж байгааг анхаарах шаардлагатай байв. Байгууллагын үйл ажиллагааны тухай тодорхой ойлголт өгч, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдэд ойлгомжтой мэдээлэл өгч, зохистой шаардлага тавьж ажиллахад анхаарах нь зүйтэй.

Шинээр хэрэгжиж эхэлсэн шүүхийн тахарын үйл ажиллагаатай холбогдуулан дараах Зөвлөмжийг гаргаж байна:

1. Тахарын албаны зүгээс хохирогчийг хамгаалах, тэдэнд шүүх хуралдаанд оролцоход нь шаардлагатай хууль зүйн туслалцаа, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлд санаачилгатай, идэвх зүтгэлтэй ажиллах;
2. Тахарын албатай хамтран ажиллаж, харуул хуягийн ажлын байрны тодорхойлолтод иргэдэд мэдээлэл өгөх чиг үүргийг оруулах, эс бөгөөс энэ чиг үүргийг гүйцэтгүүлэх шинэ ажлын байр шүүхэд бий болгох;
3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэг мөр болгож хуульд заасан журмын дагуу оролцуулах, шаардлагатай зохицуулалт журмыг эцэслэх;
4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх танхимд заавал уншиж танилцуулах;
5. Шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, техник тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулахад анхаарах;
6. Шүүх хуралдааны видео бичлэгийн бүрэн бүтэн байдалд онцгой хяналт тавьж ажиллах, судалгаа шинжилгээний зорилгоор үзэж ашиглах боломжийг нээх талаар судлах;
7. Шүүхийн захиргааны ажилтнуудын ёс зүйн асуудлаар хяналт тавьж, зохих удирдамж, сургалтаар хангах.

## **В. Шүүхийн байрны тохижилт, хүндэтгэл төрүүлэхүйц байдал**

Шүүхийн байр болон шүүх танхим нь олон нийтэд хүндэтгэл төрүүлэхүйц байхаас гадна шударгаар шүүлгэх эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлийг хангасан, хүртээмжтэй байх шаардлагатай.

Шүүхийн захиргааны тухай хуулийн дагуу ШЕЗ-ийн 2014 оны 7 дугаар сарын 18-ны 100-р тогтоолоор “Шүүхийн байрны нийтлэг шаардлага”-ыг баталсан байдаг. Үүнд шүүхийн танхим нь шүүх хуралдааныг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, эрүүл аюулгүй байх хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж заажээ. Мөн гар утасны сүлжээ хязгаарлагч байрлуулах тухай заасан байдаг.

### **Ажиглалтын дүн**

Ажиглалтаар шүүхийн байр болон шүүх хуралдааны танхимын цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байдалд 6.4 хувь нь сөрөг дүгнэлт өгчээ. Түүнчлэн шүүх хуралдаанд оролцогчдын яриа харилцан сонсогдохгүй, техник хэрэгсэл нь хэвийн бус байгааг ажиглажээ. Ажиглалт хийсэн нийт шүүх хуралдааны 4.5 хувьд шүүх хуралдааны микрофон эвдрэлтэй байжээ. Мөн зөвхөн 16.6 хувьд л нотлох баримтыг дуу, дүрс бичлэгээр харуулах боломж хангагдсан байжээ.

*Шүүхийн байрны цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байсан эсэх  
(2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулснаар)*

Шүүхүүд	2015 он	2010 он
Дүүргийн эрүүгийн анхан шатны 1-р шүүх	90.0 %	66.7 %
Дорнод аймгийн шүүх	93.5 %	90.0 %
Хөвсгөл аймгийн шүүх	100 %	100 %
Төв аймгийн шүүх	100 %	-

Шүүхийн ажиглалт төслийн бэлтгэл ажлын хүрээнд ажиглалт хийх шүүхийн байртай урьдчилан танилцсан бөгөөд байр байдлын хувьд харьцангуй шийдэгдсэн, шилжилт хөдөлгөөн дууссан шүүхийг сонгож авсан болно. Хөвсгөл аймгийн шүүхийн хувьд шүүхийн байранд Прокурорын газар хамт байрладаг бөгөөд өрөө тасалгааны зохион байгуулалтын хувьд иргэдтэй өдөр тутам харилцдаг захиргааны ажилтнууд хамгийн дээд давхарт байрладаг зэрэг дутагдал ажиглагдсан.

*Шүүх хуралдааны танхимын цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байсан эсэх  
(2010 оны ажиглалтын дүнтэй харьцуулснаар)*

Шүүхүүд	2015 он	2010 он
Дүүргийн эрүүгийн анхан шатны 1-р шүүх	93.3 %	56.1 %
Дорнод аймгийн шүүх	92.6 %	80.0 %
Хөвсгөл аймгийн шүүх	100 %	100 %
Төв аймгийн шүүх	100%	-

Дүүргийн 1-р шүүхийн шүүх хуралдааны “В” танхимд сандал эвдэрсэн байсан ба суудал хүрэлцэхгүй байсан.

Шүүхүүдэд хувцасны өлгүүр байдаггүйгээс танхимд гадуур хувцсаа барьж суух хэрэгтэй болдог.

Дээрх хүснэгтүүдээс харахад шүүхийн байр, хуралдааны танхимын тохижилт, цэвэр цэмцгэр байдалд 2010 оныхоос ахиц гарсан нь харагдаж байна.

Шүүхийн байр болон шүүх хуралдааны танхимын тохижилт, цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байдлын талаарх Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй:

1. Шүүхийн байранд өлгүүр ажиллуулах, шүүх хуралдааны танхимын тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;
2. Шүүх хуралдааны танхимд гар утасны сүлжээ хязгаарлагчийг танхим бүрт ажиллуулах, гар утас ашиглахыг бүрэн хориглох;
3. Шүүх хуралдааны танхимын техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ажиллагааг жигдэлж, хэвшүүлэхэд Тамгын газар анхаарал тавьж ажиллах шаардлагатай байна.

# ХАВСРАЛТ

## Шүүх хуралдааны ажиглалтын хуудас

Ажиглагчдын мэдээлэл:

Код:

1. \_\_\_\_\_
2. \_\_\_\_\_

A. Шүүх хуралдааны ерөнхий мэдээлэл:

1. Шүүхийн ажиглалтын огноо: \_\_\_\_\_
2. Шүүх хуралдаан нь:
  - а) Анхны удаа
  - б) Хойшилсон хуралдаан
3. Шүүх хуралдааны хуваарьт цаг: \_\_\_\_\_
4. Шүүх хуралдаан эхэлсэн цаг: \_\_\_\_\_
5. Шүүх хуралдаан дууссан цаг: \_\_\_\_\_
6. Шүүх хуралдаан хойшилсон эсэх: *Тийм*      *Үгүй*
7. Хойшилсон шалтгааныг мэдээлсэн цаг: \_\_\_\_\_
8. Шүүх хуралдаан хойшлогдсон бол хэнээс шалтгаалсан бэ (шалтгааныг бичнэ үү)?
  - а) Шүүгч:
    - 1) Цаг тухайд нь мэдэгдээгүй
    - 2) Өвчтэй
    - 3) Томилолттой
    - 4) Хурал давхардсан
    - 5) Тодорхойгүй
  - б) Улсын яллагч:
    - 1) Цаг тухайд нь мэдэгдээгүй
    - 2) Өвчтэй
    - 3) Томилолттой
    - 4) Хурал давхардсан
    - 5) Тодорхойгүй

- в) Өмгөөлөгч
  - 1) Цаг тухайд нь мэдэгдээгүй
  - 2) Өвчтэй
  - 3) Томилолттой
  - 4) Хурал давхардсан
  - 5) Тодорхойгүй
- г) Бусад оролцогч
  - 1) Цаг тухайд нь мэдэгдээгүй
  - 2) Өвчтэй
  - 3) Томилолттой
  - 4) Хурал давхардсан
  - 5) Тодорхойгүй

9. Хойшилсон шалтгааныг хэн танд мэдээлсэн бэ? \_\_\_\_\_

10. Хойшилсон шалтгааныг оролцогчдод урьдчилан мэдэгдэх боломжтой байсан эсэх?

*Тийм*                      *Үгүй*

11. Хуралдаан хойшлуулах хүсэлт гаргасан байдал:

- а) утсаар
- б) бичгээр
- в) амаар
- г) тодорхойгүй

12. Хэргийн зүйлчлэл: \_\_\_\_\_

### Б. Шүүх хуралдааны оролцогчдын талаарх мэдээлэл

1. Шүүх бүрэлдэхүүн (доорх хариултаас сонгож тэмдэглэнэ үү):

- а) Шүүгч дангаар
- б) Шүүх бүрэлдэхүүн

2. Шүүх хуралдааны даргалагчийн овог, нэр: \_\_\_\_\_

Шүүгчийн овог, нэр: \_\_\_\_\_

Шүүгчийн овог, нэр: \_\_\_\_\_

3. Шүүгдэгчийн талаарх мэдээлэл:

Овог, нэр: \_\_\_\_\_

Иргэний харьяалал: \_\_\_\_\_

Өмнө ял эдэлж байсан эсэх: \_\_\_\_\_

Боловсрол/Мэргэжил: \_\_\_\_\_

Овог нэр: \_\_\_\_\_

Иргэний харьяалал: \_\_\_\_\_

Өмнө ял эдэлж байсан эсэх: \_\_\_\_\_

Боловсрол/ Мэргэжил: \_\_\_\_\_

Овог нэр: \_\_\_\_\_

Иргэний харьяалал: \_\_\_\_\_

Өмнө ял эдэлж байсан эсэх: \_\_\_\_\_

Боловсрол/ Мэргэжил: \_\_\_\_\_

4. Улсын яллагчийн овог, нэр: \_\_\_\_\_

5. Шүүгдэгчийн өмгөөлөгч оролцсон эсэх: *Тийм* *Үгүй*

6. Өмгөөлөгчийн овог нэр: \_\_\_\_\_

Өмгөөлөгчийн овог нэр: \_\_\_\_\_

Өмгөөлөгчийн овог нэр: \_\_\_\_\_

7. Шүүгдэгч өмгөөлөгчөө өөрөө сонгож, гэрээлж авсан уу? *Тийм* *Үгүй*

8. Шүүгдэгч төрөөс томилогдсон өмгөөлөгч (улсын өмгөөлөгч) авсан уу?  
*Тийм* *Үгүй*

9. Шүүх хуралдаанд хохирогч оролцсон эсэх: *Тийм* *Үгүй*

10. Хохирогчийн өмгөөлөгч оролцсон эсэх: *Тийм* *Үгүй*

11. Өмгөөлөгчийн овог нэр: \_\_\_\_\_

12. Шүүгдэгч орчуулагч/ хэлмэрч авах хүсэлт гаргасан эсэх: *Тийм* *Үгүй*



13. Хүсэлтийг хангасан эсэх: *Тийм* *Үгүй*

Ямар хэлээр: \_\_\_\_\_

14. Шүүгдэгч, хохирогч, гэрч хэлгүй, дүлий тохиолдолд дохионы хэлний хэлмэрч байсан эсэх? *Тийм* *Үгүй*

15. Шүүх хуралдаанд яллах талын гэрч оролцсон эсэх *Тийм* *Үгүй*

16. Шүүх хуралдаанд цагаатгах талын гэрч оролцсон эсэх *Тийм* *Үгүй*

17. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон эсэх: *Тийм* *Үгүй*

Оролцсон бол тэдний овог нэр: 1. \_\_\_\_\_

2. \_\_\_\_\_

3. \_\_\_\_\_

### В. Шүүх хуралдааны нээлттэй байдал

1. Шүүхийн байранд нэвтэрсэн байдал:

а) ямар ч саадгүй нэвтэрсэн

б) шүүхийн харуул хуяг бичиг баримт шалгаж, бүртгэж оруулсан

в) шүүхийн харуул хуяг оруулахаас татгалзсан, шалтгаан \_\_\_\_\_

2. Шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал:

а) ямар ч саадгүй нэвтэрсэн

б) шүүх хуралдааны журам сахиулах хуяг биеийн байцаалт шалгаж оруулсан

в) шүүх хуралдааны журам сахиулах хуяг оруулахаас татгалзсан, шалтгаан: \_\_\_\_\_

г) шүүх хуралдааны танхимд орохыг хориглосон. Хэн? \_\_\_\_\_

Шалтгаан: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

3. Нээлттэй шүүх хуралдаанд оролцоход зөвшөөрөл авах шаардлагатай байсан уу? *Тийм* *Үгүй*

4. Тийм бол хэнээс?  
 а) шүүгч  
 б) шүүхийн нарийн бичгийн дарга  
 в) шүүхийн хуяг  
 г) шүүхийн захиргааны бусад ажилтан
5. Шүүх хуралдаан нээлттэй журмаар явагдсан эсэх: *Тийм* *Үгүй*
6. Нээлттэй зарлагдсан шүүх хуралдааныг хаалттай явуулахаар шийдвэрлэсэн үү? *Тийм* *Үгүй*
7. Тийм бол шалтгаан: \_\_\_\_\_
8. Нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй хүн болгоныг оруулсан эсэх: *Тийм* *Үгүй*
9. Үгүй бол ямар шалтгаанаар: \_\_\_\_\_

Г. Хараат бус, бие даасан, шударга шүүхээр шүүлгэх эрх

1. Шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах эрхийг шүүгч тайлбарлаж өгсөн эсэх? *Тийм* *Үгүй*
2. Доорх этгээдүүдийг татгалзан гаргах хүсэлт тавьсан эсэх:  
 а) Даргалагч шүүгч *Тийм* *Үгүй*  
 б) Оролцогч шүүгч *Тийм* *Үгүй*  
 в) Бусад этгээд \_\_\_\_\_ *Тийм* *Үгүй*
3. Хэрэв тийм бол хүсэлтийг биелүүлсэн эсэх?  
*Тийм* \_\_\_\_\_  
*Үгүй* \_\_\_\_\_
4. Шүүгч хэргийг алагчлалгүй шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрсөн үү? *Тийм* *Үгүй*
5. Шүүгдэгчийн эрх, үүргийг сануулсан эсэх: (сануулаагүй эрхийн өмнөх тоог дугуйлах)  
 1. Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх  
 2. Яллах тогтоолтой танилцах  
 3. Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах  
 4. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах  
 5. Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах

6. Нотлох баримт гаргаж өгөх болон шалгуулах
7. Хэргийн материалтай танилцах
8. Шүүх хуралдаанд оролцох
9. Шүүх хуралдааны оролцогчийг татгалзан гаргах
10. ЭБША-ны талаар гомдол гаргах
11. Шинжээчийн дүгнэлттэй танилцах
12. Эх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч хэлмэрч авах
13. Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх
14. Шүүхийн тогтоолд гомдол гаргах
15. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх болон гэм буруутай эсэхээ нотлох үүрэг хүлээхгүй байх
16. Шүүхээс дуудсан цагт ирэх үүрэгтэй
17. Шүүх хуралдааны дэгийг сахих үүрэгтэй
18. Шүүхийн шийдвэрт саад болохгүй байх үүрэгтэй.

6. Шүүгч шүүх хуралдааны оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгсөн эсэх: *Тийм* *Үгүй*

7. Яллагчийн уншиж сонгосон яллах дүгнэлт шүүгдэгчийн гардаж авсантай таарч байгааг тодруулсан эсэх: *Тийм* *Үгүй*

8. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүх хуралдааны үеэр талууд идэвхтэй мэтгэлцсэн эсэх: *Тийм* *Үгүй*

9. Шүүх бүрэлдэхүүн хэлэлцүүлгийн үеэр танхимыг түр орхин гарсан уу? *Тийм* *Үгүй*

10. Шүүгч нарын анхаарал төвлөрөлд таны өгөх үнэлгээ:

а) хоорондоо ярилцах

б) гар утсаа ашиглах

в) өөр хэргийн материал унших

г) бусад хэлбэрээр \_\_\_\_\_

11. Шүүгчид зөвлөлдөх тасалгаанд шийдвэр гаргах үед ямар нэг байдлаар саад болсон уу? *Тийм* *Үгүй*

12. Тийм бол тодорхойлно уу? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Д. Гэм буруугүйд тооцогдох, гэм бурууг хүчээр хүлээлгэхээс ангид байх, өөрийнхөө болон гэр бүлийнхээ гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх

1. Шүүгдэгчийг гэм буруутай мэтээр сэтгэгдэл төрүүлсэн, ямарваа шинж тэмдэг байсан уу?  
а) гав зүүлгэх,  
б) хорих байрны дүрэмт хувцас өмсүүлэх  
в) тусгай хаалтны ард суулгах  
г) шинж тэмдэг илрээгүй
2. Улсын яллагчтай харьцуулахад өмгөөлөх тал хүчин чадал сул байсан эсэх?  
*Тийм* *Үгүй*
3. Шүүхийн хэлэлцүүлгийн үеэр улсын яллагч шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж илт буруутгаж харьцсан уу?  
*Тийм* *Үгүй*
4. Шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгч шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан уу?  
*Тийм* *Үгүй*
5. Шүүгдэгчийн өөрөө өөрийнхөө эсрэг болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгсөн үү?  
*Тийм* *Үгүй*
6. Шүүгдэгч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан уу?  
*Тийм* *Үгүй*
7. Шүүгч шүүгдэгчийг асуултад хариулах үүрэггүй болон асуултад хариулахаас татгалзах нь өөрийнх нь эсрэг ашиглагдахгүй болохыг шүүгдэгчид тайлбарлаж өгсөн үү?  
*Тийм* *Үгүй*
8. Шүүгдэгчид гэм бурууг нь хүлээлгэхээр шүүгч дарамталсан уу?  
*Тийм* *Үгүй*
9. Шүүгч шүүгдэгчийг улсын яллагчтай гэм буруугаа хүлээн зөвшөөрөх тохиролцоонд хүрэхийг зөвлөсөн үү?  
*Тийм* *Үгүй*
10. Шүүгч шүүх хуралдааныг хурдан дуусгахаар хичээж байсан уу?  
*Тийм* *Үгүй*
11. Шүүгдэгч шүүхэд мэдүүлэг өгч байхад нь ямар нэг байдлаар тасалдуулсан уу?  
*Тийм* *Үгүй*
11. Хэрэв тийм бол, хэн, хэрхэн? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## Е. Нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрх

1. Шүүгдэгчийг байцааж байхад саад болсон уу? Тийм Үгүй
2. Хэрэв тийм бол, хэн, хэрхэн? \_\_\_\_\_
3. Өмгөөлөгчийн гаргаж өгсөн нотлох баримт, гомдлыг үндэслэлгүйгээр хассан уу? Тийм Үгүй
4. Шүүх нотлох баримтыг хасах талаар баримталсан үндэслэл:
  - а) хэрэгт холбогдолгүй
  - б) хууль/журам зөрчиж авагдсан
  - в) нотолгооны шинжээ алдсан
  - г) бусад \_\_\_\_\_
5. Нотлох баримтыг ямар хэлбэрээр танилцуулсан бэ? (1-ээс дээш хариулт сонгож болно)
  - а) Материаллаг нотлох баримтыг гаргаж үзүүлэх хэлбэрээр
  - б) Гэрчийн мэдүүлгийг уншиж сонсгох хэлбэрээр
  - в) Шинжээчийн дүгнэлтийг уншиж сонсгох хэлбэрээр
  - г) Гэрч, шинжээчийг оролцуулах мэдүүлэг авах хэлбэрээр
  - д) Дуу, дүрс бичлэг үзүүлэх хэлбэрээр
  - е) Бусад хэлбэрээр \_\_\_\_\_
6. Дуу, дүрс бичлэгээр үзүүлэх нотлох баримтыг бүрэн, тодорхой үзүүлэх боломж, нөхцөл хангагдсан байсан уу? Тийм Үгүй
7. Шүүгдэгч болон түүний өмгөөлөгчид доорх боломж байсан эсэх:
  - а) Хэргийн материалтай танилцах Тийм Үгүй
  - б) Яллагчийн нотлох баримт, фактын талаар асуулт тавих Тийм Үгүй
  - в) Гэрч болон шинжээчийг байцаах Тийм Үгүй
  - г) Шинээр нотлох баримт танилцуулах Тийм Үгүй
8. Шүүх хуралдаанд байцаалт өгөхөөс нь өмнө гэрчийг шүүх хуралдааны танхимд оруулсан уу? Тийм Үгүй
9. Нотлох баримтыг шинжлэх дарааллыг тогтоохдоо талуудын саналыг харгалзсан уу? Тийм Үгүй
10. Шүүгдэгчээс хэн эхэлж мэдүүлэг авсан?
  - а) Улсын яллагч
  - б) Өмгөөлөгч
11. Шүүх хуралдаанд гэрч оролцсон уу? Тийм Үгүй

12. Мэдүүлэг өгөхтэй холбоотой гэрчийн эрхийг тайлбарлаж өгсөн эсэх?  
Тийм Үгүй
13. Худал мэдүүлэг өгсний төлөө хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг гэрчид сануулсан уу?  
Тийм Үгүй
14. Шүүх хуралдааны оролцогчдын зүгээс гэрчээс мэдүүлэг авахад сэтгэл зүйн болон бусад дарамт үзүүлсэн үү?  
Тийм Үгүй
15. Шүүх хуралдааны үеэр өгсөн гэрчийн мэдүүлэг мөрдөн байцаалтын явцад өгсөн мэдүүлэгтэй нь зөрсөн үү?  
Тийм Үгүй
16. Тийм бол зөрүүнд хэн, ямар тайлбар хийсэн бэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
17. Шүүх хуралдаанд шинжээч оролцсон уу? Тийм Үгүй
18. Шинжээчид эрхийг нь тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
19. Шүүх хуралдааны үеэр шинжээчээс мэдүүлэг авсан уу? Тийм Үгүй
20. Тийм бол хэний санаачлагаар? \_\_\_\_\_
21. Шинжээчээс татгалзах шүүгдэгчийн эрхийг шүүгч тайлбарлаж өгсөн үү?  
Тийм Үгүй
22. Шинжээчийн дүгнэлтийг хэлэлцсэний дараа нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх асуудлаар хэргийн оролцогчид хүсэлт гаргасан уу? Тийм Үгүй
23. Нотлох баримтаа дэмжих ямарваа нэмэлт санаа байгаа эсэх талаар шүүгч талуудаас асуусан уу? Тийм Үгүй
24. Мөрдөн байцаалтын үеэр шүүгдэгчид сэтгэлзүйн болон бие махбодийн дарамт учруулсан (албадлага), эрүү шүүлт хэрэглэсэн, хэрцгий харьцсан, заналхийлсэн, хууран мэхлэх болон бусад хууль бус арга хэрэгслийг ашигласан хэмээн шүүгдэгч өмнө өгсөн мэдүүлгээсээ буцсан уу?  
Тийм Үгүй
25. Шүүгдэгчид сэтгэлзүйн болон бие махбодийн дарамт учруулсан (албадлага), эрүү шүүлт хэрэглэсэн, хэрцгий харьцсан, заналхийлсэн, хууран мэхлэх болон бусад хууль бус арга хэрэгслийг ашиглан олж авсан гэх нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлсэн үү? Тийм Үгүй
26. Хууль бусаар олж авсан гэсэн үндэслэлээр нотлох баримтаас хасуулах хүсэлт гарсан уу? Тийм Үгүй

### Ж. Талуудын тэгш байдал

1. Улсын яллагч хэрэгт холбогдох ямар нэг хүсэлт тавьсан уу? *Тийм* *Үгүй*
2. Тийм бол шүүгч хүсэлтийг хангасан уу? *Тийм* *Үгүй*
3. Үгүй бол хүсэлтийг хангахаас татгалзсан үндэслэл юу байсан бэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Шүүгч шүүх хуралдааны оролцогч аль нэг талд нотлох баримт цуглуулахад тусалсан уу? *Тийм* *Үгүй*
5. Хэрэв тийм бол хэрхэн тусалсныг тодорхойлно уу? \_\_\_\_\_
6. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд хэн эхэлж үг хэлсэн?
  - а) Өмгөөлөгч
  - б) Улсын яллагч
  - в) Мэдэхгүй
7. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд улсын яллагчийн зүгээс ялын дүгнэлтийг өөрчлөх санал гаргасан уу? *Тийм* *Үгүй*
8. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд өмгөөлөгчийн зүгээс ялын асуудлаар санал гаргасан уу? *Тийм* *Үгүй*
9. Талуудад хэлэлцүүлгийн шатанд үг хэлэхийг зөвшөөрсөн үү? *Тийм* *Үгүй*
10. Шүүгдэгчийг эцсийн үгээ хэлэхэд ямар нэг саад учирсан уу? *Тийм* *Үгүй*

### 3. Өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрх

1. Шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх боломжийг нь хаасан, хязгаарласан ямар нэг саад бэрхшээл ажиглагдсан уу? *Тийм* *Үгүй*
2. Хэрэв тийм бол тодорхойлно уу? \_\_\_\_\_
3. Шүүх хуралдааны үеэр шүүгдэгчийн өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчтэй харилцаж байсан харилцааны хэв маягийг тодорхойлно уу?
  - а) хэвийн
  - б) хүйтэн, дээрэнгүй
  - в) үл тоомсорлосон
  - г) огт харьцаагүй
  - д) мэдэхгүй

4. Шүүх хурлын үеэр өмгөөлөгч шүүгдэгчтэй харилцах боломжийг тодорхойлно уу?
  - а) харилцах боломжтой зэрэгцэж суусан байсан
  - б) харилцан ярилцах боломжгүй байсан
  - в) харилцахыг даргалагч шүүгч хориглож байсан
  - г) хурлын дэгд захирагдахыг шаардаж байсан
5. Шүүгдэгч мэргэжлийн, чанартай, үр дүнтэй өмгөөллөөр хангагдаж чадсан уу? Тийм      Үгүй
6. Хохирогч мэргэжлийн, чанартай, үр дүнтэй өмгөөллөөр хангагдаж чадсан уу? Тийм      Үгүй

#### И. Орчуулагч хэлмэрч авах эрх

1. Орчуулагчийн эрхийг шүүгч тайлбарлаж өгсөн үү? Тийм      Үгүй
2. Худал орчуулсан тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар орчуулагч/хэлмэрчид сануулсан уу? Тийм      Үгүй
3. Орчуулагч/хэлмэрчийг татгалзан гаргах эрхийг нь талуудад тайлбарлаж өгсөн үү? Тийм      Үгүй
4. Хуулийн дагуу өмгөөлөгчид гардуулан өгөх ёстой, шүүхийн баримт бичгүүдийн орчуулгын бичмэл хувийг шүүх хуралдааны явцад шүүгдэгчид өгсөн үү? Тийм      Үгүй

#### К. Шүүхийн шийдвэр

1. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ямар хэлбэрээр хөтөлсөн бэ? (1-ээс дээш хариулт сонгож болно)
  - а) Гараар бичиж
  - б) Компьютерт шивж
  - в) Аудио/ видео бичлэгээр
  - г) Бусад хэлбэрээр
2. Шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах эрхийн талаар шүүгч тайлбарласан уу? Тийм      Үгүй
3. Шүүхийн шийдвэрийн агуулга:
  - а) Шүүгдэгчийг цагаатгасан
  - б) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон
  - в) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн



- г) Хавтаст хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан
- д) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч тэнссэн
- е) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч хойшлуулсан
- ё) Бусад \_\_\_\_\_

4. Ялын төрөл (ялын хэмжээг ард нь бичнэ үү):

- а) Торгох
- б) Үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах
- в) Эд хөрөнгө хураах
- г) Албадан ажил хийлгэх
- д) Баривчлах
- е) Хорих ял
- ё) Хорих ялыг тэнсэх
- ж) Бусад \_\_\_\_\_

5. Шүүхийн тогтоолд давж заалдах эрхийг сануулсан уу? *Тийм* *Үгүй*

6. Шүүгч тогтоолыг шүүгдэгчдэд тайлбарлаж ойлгуулсан уу? *Тийм* *Үгүй*

7. Ажиглагчийн дүгнэж байгаагаар тогтоол нь:

- а) Хангалттай нотлох баримтад тулгуурлаж гарсан *Тийм* *Үгүй*
- б) Хагас дутуу байдлаар үнэлж шийдвэр гарсан *Тийм* *Үгүй*

8. Ажиглагчын дүгнэж байгаагаар шүүгч:

- а) Объектив байдлаар фактад тургуурлаж шийдвэр гаргасан *Тийм* *Үгүй*
- б) Талуудад адил тэгш боломж олгож байсан *Тийм* *Үгүй*

9. Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг уншиж сонсгосон уу? *Тийм* *Үгүй*

10. Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийн агуулга: \_\_\_\_\_

11. Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлт үндэслэл сайтай байсан уу?  
*Тийм* *Үгүй*

Л. Шүүхийн нөхцөл байдал болон шүүгч, шүүхийн ажилтнуудын харилцааны байдал

1. Шүүхийн байр нь цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байсан уу?  
*Тийм* *Үгүй*

2. Шүүх хуралдааны танхим цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байсан уу?  
*Тийм* *Үгүй*

3. Шүүх хуралдаанд оролцогчдын яриа харилцан сонсогдохуйц байсан уу?  
Тийм Үгүй
4. Шүүх хуралдааны танхимын микрофон, чанга яригч хэвийн ажиллагаатай байсан уу?  
Тийм Үгүй
5. Шүүгч өмсгөлөө өмссөн байсан эсэх: Тийм Үгүй
6. Шүүх бүрэлдэхүүн орж ирэхэд шүүхийн танхимд байсан хүмүүс босож хүндэтгэл үзүүлсэн эсэх: Тийм Үгүй
7. Шүүх хуралдааны дэгийг оролцогчдод тайлбарлаж таниулсан эсэх: Тийм Үгүй
8. Шүүхийн танхимд журам сахиулах хуяг байсан эсэх: Тийм Үгүй
9. Шүүхийн журам сахиулах хуяг хуралдааныг дуустал танхимаас гараагүй юу? Тийм Үгүй
10. Шүүхийн танхимын дэг зөрчигдөж байсан уу?, тийм бол шүүгч ямар арга хэмжээ авсан бэ?  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
11. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны бэлтгэлийг бүрэн хангасан байсан уу? Тийм Үгүй
12. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шаардлагатай техник хэрэгслийг хуралдаан эхлэхээс өмнө бэлэн болгосон уу? Тийм Үгүй
13. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга албаны байдлаар хувцасласан байсан уу? Тийм Үгүй
14. Шүүх хуралдаан эхлэхэд бүх оролцогчид зохих байраа эзэлсэн байсан уу? Тийм Үгүй
15. Шүүх хуралдааны үеэр аудио видео бичлэг хийгдэж байсан эсэх: Тийм Үгүй
16. Шүүхийн харуул хуягийн иргэдтэй харилцах байдал таны ажигласнаар:  
а) Эелдэг, уриалгахан  
б) Энгийн  
в) Хөндий хүйтэн  
г) Бүдүүлэг, дээрэнгүй  
д) Ялгамжтай  
е) Мэдэхгүй

17. Шүүхийн нарийн бичгийн даргын харилцаа таны ажигласнаар:
- а) Эелдэг, уриалгахан
  - б) Энгийн
  - в) Хөндий хүйтэн
  - г) Бүдүүлэг, дээрэнгүй
  - д) Ялгамжтай
  - е) Мэдэхгүй
18. Шүүхийн дэг сахиулах хуягийн харилцаа таны ажигласнаар:
- а) Эелдэг, уриалгахан
  - б) Энгийн
  - в) Хөндий хүйтэн
  - г) Бүдүүлэг, дээрэнгүй
  - д) Ялгамжтай
  - е) Мэдэхгүй
19. Шүүгч шүүх хуралдааны оролцогч нартай харилцах байдал таны ажигласнаар:
- а) Эелдэг, уриалгахан
  - б) Энгийн
  - в) Хөндий хүйтэн
  - г) Бүдүүлэг, дээрэнгүй
  - д) Ялгамжтай
  - е) Мэдэхгүй

**Огноо/ Газар:**

\_\_\_\_\_

**Ажиглагчийн гарын үсэг:**

1. \_\_\_\_\_

2. \_\_\_\_\_

*(Бусад анхаарал татсан, мэдээлбэл зохих асуудлыг бичгээр хавсарган хуудас тус бүрт асуулгын хуудасны кодыг тавьж гарын үсэг зурж баталгаажуулна.)*

## **ШҮҮХИЙН АЖИГЛАГЧИД:**

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1-р шүүхэд ажиглалт хийсэн:

1. Э.Сувд
2. М.Бүжин
3. Б.Шинэбаяр
4. Д.Алтангэрэл
5. Ц.Ариунгэрэл
6. Н.Мөнхтуяа
7. Б.Нямсүрэн
8. Г.Ариунсанаа
9. Г.Ууганзаяа
10. Г.Хэрлэнчимэг

Сум дундын 10-р шүүхэд ажиглалт хийсэн:

11. Э.Алтантуяа
12. Д.Мөнхзаяа
13. Б.Батаа
14. Ш.Баяржаргал

Сум дундын 23-р шүүхэд ажиглалт хийсэн:

15. Д.Нарантуяа
16. Д.Оюун
17. Ц.Оюун
18. Ц.Батсайхан

Сум дундын 27-р шүүхэд ажиглалт хийсэн:

19. Ж.Бямбажав
20. Д.Лхагвацогт
21. С.Лонжид
22. Г.Чимгээ